

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТ 2021 ОНД 81 ХУВЬ, 2022 ОНД 27 ХУВЬТАЙ БАЙНА.**

АУДИТЫН СЭДЭВ: БНАТ-ИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АУДИТЫН КОД: ГАА-2023/30-ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу
Цахим хуудас: www.tailan.audit.mn

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор **Х.Түвшинбаяр**
Утас: 70483413 цахим хуудас: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер **Д.Эрдэнэчимэг**
Утас: 70484055 цахим хуудас: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор Ж.Бүжинханд
Утас: : 70484030 цахим хуудас: Bujinkhandj@audit.gov.mn

Аудитор Э.Сүнжидмаа
Утас: : 70484030 цахим хуудас: Sunjidmaae@audit.gov.mn

Аудитор Ц.Сайханжаргал
Утас: : 70484030 цахим хуудас: Saikhanjargalts@audit.gov.mn

Аудитор М.Атарцэцэг
Утас: : 70484030 цахим хуудас: Atartsetsegm@audit.gov.mn

Аудитор С.Санчирмаа
Утас: : 70484030 цахим хуудас: Sanchirmaas@audit.gov.mn

Алтай хот 2023 он

Тайланг хянасан:

Говь-Алтай аймаг дахь Төрийн
аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор
Х.Түвшинбаяр

Тайланг бэлтгэсэн:

Аудитын менежер
Д.Эрдэнэчимэг

Ахлах аудитор Ж.Бүжинханд
Ахлах аудитор Б.Цэвэлмаа
Аудитор Э.Сүнжидмаа
Аудитор Ц.Сайханжаргал
Аудитор М.Атарцэцэг
Аудитор С.Санчирмаа
Аудитор Н.Гэрэлмаа
Аудитор М.Дөлгөөнбаяр

2023 оны 6 дугаар сарын 19-
ний өдөр

Тайланг УАГ-ын
цахим хуудаснаас үзнэ үү:
www.audit.mn

Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70484030 дугаарын утсаар
харилцана уу.

ХАЯГ:

Говь-Алтай аймаг дахь
Төрийн аудитын газар
Говь-Алтай аймаг Есөнбулаг
сум Жинст баг 1402 тоот

АГУУЛГА**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР 3****ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ 6****БҮЛЭГ А. БНАТ-ИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН
ОРЧНЫГ САЙЖРУУЛЖ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ
ХАНГАХ ХӨШҮҮРГИЙГ БИЙ БОЛГОХООР БАЙНА. 7**

А1. Аймгийн бодлогын баримт бичигт байгаль орчныг хамгаалах,
байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбоотой дэвшүүлсэн
зорилтыг хэрэгжүүлж байна. 7

А2. БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахын тулд эрх
бүхий албан тушаалтны хамтран ажиллах гэрээнд тухайн
жилийн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх,
хяналт тавих арга хэмжээ, зарцуулах төсвийг шалгуур үзүүлэлт
бүрээр тусган хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллах
шаардлагатай байна. 14

**БҮЛЭГ Б. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ
АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН
ХЭСГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ
ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА. 17**

Б1. Байгалийн нөөцийг бүрэн тогтоогоогүй байхад ашиглах
шийдвэр олгож, төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх
харилцааг журмын дагуу хэрэгжүүлээгүй байна. 17

Б2. Төлбөрийн орлогын хэсгийг хуулийн дагуу төлөвлөж,
зарцуулаагүй байна. 24

**БҮЛЭГ В. БНАТ-ИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДҮН
ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ ТОХИРОХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ
АЖИЛЛААГҮЙ БАЙНА. 28****В1. ТӨРИЙН БОЛОН НУТГИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН УЯЛДАА ХОЛБООГҮЙГЭЭС
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ,
ЗАРДЛЫН НЭГДСЭН МЭДЭЭЛЭЛ ЗӨРҮҮТЭЙ БАЙНА. 28**

В2. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас БНАТ-ийн тухай
хуулийн хэрэгжилтэд хяналт хийж үр дүнг хэлэлцээгүй байна. 30

**ДҮГНЭЛТ: БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ 2021 ОНД 81 ХУВЬ, 2022 ОНД 27
ХУВЬТАЙ БАЙНА. 33****ЗӨВЛӨМЖ 33****АЛБАН ШААРДЛАГА 34****ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ: 35**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБӨУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт
АНТАГ	Аймаг, нийслэлийн Төрийн аудитын газар
БИОФИН	Биологийн олон янз байдлын санхүүжилтийн санаачилга
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
БОАЖГ	Байгаль орчин аялал, жуулчлалын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НА	Нийцлийн аудит
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
УИХ	Улсын Их Хурал

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	9
Хүснэгт 2	Говь-Алтай аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилт	9
Хүснэгт 3	Говь-Алтай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилт	10
Хүснэгт 4	Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилт	11
Хүснэгт 5	Ойн зохион байгуулалтын ажлын тайлан	12
Хүснэгт 6	Ан агнуурын менежментийн төлөвлөгөө	13
Хүснэгт 7	Аймгийн Засаг дарга сумын Засаг дарга, харьяа төсөв захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилт	15
Хүснэгт 8	Судалгааны талбайд хамрагдсан эх үүсвэрүүдийн ашиглах боломж	16
Хүснэгт 9	Ан амьтны нөөц ашиглах зөвшөөрөл, гүйцэтгэл	19
Хүснэгт 10	Ойгоос мод бэлтгэх дээд хэмжээ, гүйцэтгэл	19
Хүснэгт 11	Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ хийх эрх бүхий субъект	19
Хүснэгт 12	БНАТ-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	21
Хүснэгт 13	Байгалийн нөөц ашигласны орлогын ногдуулалт, гүйцэтгэл	22
Хүснэгт 14	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулбал зохих зардлын тооцоо-2022 он	24
Хүснэгт 15	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан зардлын тооцоо-2022 он /сая.төг/	25
Хүснэгт 16	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан зардлын тооцоо-2022 он /сая.төг/	25
Хүснэгт 17	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн зөрүү-2022 он /сая.төг/	26
Хүснэгт 18	БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтэд төрийн байгууллагуудын оролцоо	27
Хүснэгт 19	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн зөрүү-2022 он /сая.төг/	28
Хүснэгт 20	“БНАТ-ийн тухай хууль”-ийн хэрэгжилт /сая.төгрөг/	28

Дүрслэлийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	БНАТ-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	20

	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/04 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу аудитыг гүйцэтгэв.
Аудитын зорилт	“БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр нийцлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэв. Дээрх зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: ➤ БНАТ-ийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх; ➤ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжсэн эсэх; ➤ БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авсан эсэх.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Татварын Ерөнхий газар, аймаг, сумын ИТХ, Засаг дарга, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Усны сав газрын захиргаа, Сум дундын ойн ангийн 2021-2023 оны БНАТ-ийн хуулийн хэрэгжилттэй холбоотой үйл ажиллагааг хамруулав.
Аудитын арга зүй	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, 4001, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын зарчим, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- БНАТ-ийн тухай хууль
- Хууль тогтоомжийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Ойн тухай хууль
- Усны тухай хууль
- Амьтны тухай хууль
- Газрын тухай хууль
- Байгалийн ургамлын тухай хууль
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын хавсралт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”
- Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021 оноос 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол)
- Холбогдох бусад хууль тогтоомж эрх зүйн актууд тухай хууль актууд.

Хүндрэл бэрхшээл

Аудитаар БНАТ-ийн ногдуулалт, төлөлт, өрийн үлдэгдлийг тулгах боломжгүй, сумаас ирүүлсэн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, нотлох баримтгүй байсан нь хүндрэлтэй байлаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын хэмжээнд ногоон хөгжил, ногоон эдийн засгийг дэмжих замаар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй хандлага, үйл ажиллагааг төлөвшүүлэх, дэмжих, олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх хүрээнд агаар, орчны бохирдлыг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах, газрын доройтлыг бууруулах гэх мэт тодорхой асуудлаар хэд хэдэн бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлсэн байна.

Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, 6.2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 6 дугаар бүлэгт “Ногоон хөгжил”-ийн бодлогыг 4 зүйлд хамааруулан тусгажээ.

Харин байгаль орчны салбарт дараах бодлогын баримт бичгүүдийг батлан гаргасан байна. Үүнд:

- 1997 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 106 дугаар тогтоолоор “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого”
- 2010 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор “Ус” үндэсний хөтөлбөр”
- 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 43 дугаар тогтоолоор “Ногоон хөгжлийн бодлого”
- 2015 оны 49 дүгээр тогтоолоор “Төрөөс ойн талаар баримтлах бодлого”

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдаа холбоо, нийцлийг хангаж, давхардал, зөрчлийг арилгах зорилгоор Улсын Их Хурлын 2021 оны 89 дүгээр тогтоол¹-оор дээрх 4 бодлогын баримт бичгийг хүчингүй болгосон бөгөөд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар дахин батлагдаагүй байна.

Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг хүчингүй болгож 2022 оны 2 дугаар тогтоолоор шинэчлэн баталж хэрэгжүүлж байна.

БНАТ-ийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно.



¹ Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16381511587671>

БҮЛЭГ А. БНАТ-ИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛЖ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХӨШҮҮРГИЙГ БИЙ БОЛГОХООР БАЙНА.

А1. Аймгийн бодлогын баримт бичигт байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбоотой дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж байна.

А1.1. Эрх зүйн актын уялдаа холбоо, нийцлийг хангахын тулд хууль, тогтоомж, журамд зарим өөрчлөлт оруулахаар байна.

А1.1.1. Байгаль орчны салбарт 2020 оны байдлаар Монгол Улсын нэгдэн орж соёрхон баталсан 22 олон улсын гэрээ, конвенц, богино, дунд болон урт хугацаанд хэрэгжүүлэх 20 бодлого, хөтөлбөр, салбарын болон салбар дундын 38 хууль, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй 95 журам, аргачлал, тус салбарт шууд хамаарах 434 үндэсний стандарт мөрдөгдөж байна.

БНАТ-ийн тухай хууль 2012 онд батлагдсан бөгөөд төлбөрийн хувь хэмжээ, төлбөрөөс чөлөөлөгдөх хөнгөлөх, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хүрээнд 5 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

А1.1.2 БНАТ-ийн тухай хууль нь холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн акттай хэрхэн нийцэж байгаа талаар судаллаа. Тухайлбал:

- ✓ БНАТ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т “Газар болон түүний хэвлийн нөөц ашигласны төлбөртэй холбогдсон харилцааг тусгай хуулиар зохицуулна” гэж заасан боловч 18 дугаар зүйлийн 18.1-т “Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно: 3.газрын нөөцийн төлбөрийн орлогын 15 хувь” гэж тусгажээ. Гэтэл газрын нөөц гэсэн ойлголтыг хэрхэн авч үзэх нь тодорхойгүй байна.
- ✓ БНАТ-ийн тухай хуулийн 25.2-т “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан боловч Зөрчлийн хуульд БНАТ-ийн тухай хууль зөрчвөл оногдуулах хариуцлагын арга хэмжээг тусгаагүй.
- ✓ Засгийн газрын 2019 оны 445 дугаар тогтоолын хавсралт “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын 1.2.4-т “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны зардал” гэж Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгө, аймгийн байгаль орчны газар, сум дундын ойн ангийн үйл ажиллагааны урсгал болон хөрөнгийн зардлын нийлбэрийг” гэж заасан. Гэвч Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д урсгал зардлын хувьд зөвхөн хяналт хийх томилолтын зардлыг санхүүжүүлэхээс бусад хөрөнгийн болон урсгал зардалд зарцуулахгүй гэж заасан тул эдгээр тогтоолууд хоорондоо зөрчилдөж байна.
- ✓ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54.4-т “Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга БНАТ-ийн орлогоос олгоно”, 54.5-т “Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийн борлуулалтын орлогын 15 хувийг тухайн зөрчлийг илрүүлсэн улсын байцаагч, байгаль хамгаалагчид тухайн аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга БНАТ-ийн орлогоос олгоно.”, 54.8-т “Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн иргэн, нөхөрлөл, төрийн бус байгууллагад 150000 төгрөгийн мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга ажлын 10 өдөрт багтаан БНАТ-ийн орлогоос олгоно.”, 54.6-т “Энэ зүйлийн 4, 5, 8, 9 дахь хэсэгт заасан урамшуулал олгох журмыг Сангийн болон Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд батална.”, 24.2-т “Байгалийн баялгийн нөөцийн ашиглалтын дээд хэмжээг байгалийн тухайн баялгийг хамгаалах, зохистой ашиглах тухай хуульд заасны дагуу тогтооно.” гэж заасан боловч

- Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралт Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журамд тусгаагдаагүй.
- ✓ Ойн тухай хуулийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/282 дугаар тушаалын хавсралт "Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам"-ын 2.2.-т "Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал тухайн жилд ашиглах хуш модны самраас бусад нөөцийн дээд хязгаарыг Ойн ангийн дүгнэлтийг үндэслэн батална.", 2.3.-т "Ойн анги өөрийн хариуцсан сумдын ойн сан дахь хуш модны самрын ургацын мэдээ, дүгнэлтийг аймаг, нийслэлийн Байгаль орчны газарт 08 дугаар сарын 5-ны дотор хүргүүлнэ.", 2.4.-т "Аймаг, нийслэлийн Засаг дарга хуш модны самар бэлтгэх эсэх талаарх саналаа Ойн ангиас судлан тогтоосон ургацын мэдээ, Байгаль орчны газрын дүгнэлтийн хамт Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн оны 8 дугаар сарын 10-ны дотор багтаан хүргүүлнэ.", 2.5.-т "Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн хуш модны самар бэлтгэх эсэх талаарх санал, ургацын мэдээнд хяналтын судалгааг хийж, аль бүс нутгаас хуш модны самрыг ямар зориулалтаар бэлтгэх талаарх дүгнэлтийг тухайн оны 09 дүгээр сарын 1-ний дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.", 2.6.-т "Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь журмын 2.5-т заасан дүгнэлтийг үндэслэн хуш модны самрыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах эсвэл хориглох тухай шийдвэр, түүж бэлтгэх нөөцийн дээд хэмжээг тухайн оны 09 дүгээр сарын 10-ны дотор бүсчлэн тогтооно. гэж заасан байтал Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралт Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 2.2 дахь заалтын хугацаатай зөрчигдөж байна.

А1.2. Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичгийг батлахдаа шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тооцож төлөвлөөгүй байна.

А1.2.1. Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйл 25.1.7-д "Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна" гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор "Алсын Хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталжээ.²

"Монгол Улс 2050 он гэхэд байгаль, хэл, хил, соёлоо тогтвортой хадгалсан, нийгмийн болон эдийн засгийн хөгжлөөрөө тэргүүлэгч орон болох" Алсын хараанд төвлөрсөн 9 суурь зорилго, хөгжлийн 47 зорилттой бөгөөд 10 жилээр буюу 2020-2030 он, 2031-2040 он, 2041-2050 он гэсэн 3 үе шаттайгаар зорилт тус бүрийн үйл ажиллагааны чиглэлийг төлөвлөсөн.

Урт хугацааны бодлогын 6 дугаар зорилгыг "Байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг эрхэмлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчны тогтвортой байдлыг ханган үр өгөөжийг нь өнөө болон ирээдүй хойч үе хүртэх нөхцөлийг бүрдүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна" гэж тодорхойлсон бөгөөд 4 зорилтын хүрээнд 41 арга хэмжээг 3 үе шаттайгаар тусгаж хэрэгжүүлж байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар орон нутаг нь Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт нийцүүлэн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.³

² Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/15406>

³ Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/15403>

6.3. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь дунд болон богино хугацааны бодлого, төлөвлөлтийн үндэс байна.

6.7. Дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна.

A1.2.2. Дунд хугацааны бодлогын баримт бичгийг Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолоор “Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл батлах тухай”, 11 дүгээр тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг тус тус баталжээ.

A1.2.3. Богино хугацааны бодлогын баримт бичиг болох “Аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-г 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 26 дугаар тогтоолоор, “Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-г 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 58 дугаар тогтоолоор аймгийн ИТХ тус тус баталсан. Харин 2021 онд богино хугацааны бодлогын баримт бичиг батлагдаагүй байна.

Хүснэгт-1 Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт

№	Бодлогын баримт бичиг	Нийт		Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой			Үүнээс БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой		
		Зорилт	Арга хэмжээ	Зорилт	Арга хэмжээ	Мөнгөн дүн (сая.төг)	Зорилт	Арга хэмжээ	Мөнгөн дүн (сая.төг)
1	Аймаг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	26	153	4	19	3,761.0	1	2	0
2	Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	25	122	9	26	3,886,9	5	5	0
3	Аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө	6	75	1	6	2938.4	1	1	42.6
4	Аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө	6	91	1	13	665.3	1	3	137.5

Эх сурвалж: Аудитын ажлын баримтаас

Дээрх бодлогын баримт бичгүүдийг батлахдаа хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.7.2.6⁴, 6.7.2.в⁵ заалтад нийцүүлэн аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж батлаагүй байна.

A1.2.3. “Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д “Ногоон хөгжлийн бодлого зорилт”-ын уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлогын хүрээнд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгыг тусган хэрэгжүүлж байна. Тус арга хэмжээний хүрээнд 4 зорилтын 19 арга хэмжээг Ногоон хөгжлийн бодлого болгон тусгажээ. Үүнээс БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтийн тухайд 2021 онд 1 зорилтын хүрээнд 1 арга хэмжээг 50 хувьтай, 2022 онд 1 зорилтын 2 арга хэмжээг 90 хувьтай хэрэгжүүлжээ⁶. Үүнд:

Хүснэгт-2 Говь-Алтай аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилт

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	
		2021	2022

⁴ 6.7.2.б.Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцсон төсөл, арга хэмжээг тусгасан хөтөлбөрийг хавсаргах;

⁵ 6.7.2.в.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүнд уялдуулан орон нутгийн аливаа онцлогийг харгалзан зорилго, зорилт, хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшинг орон нутгийн түвшинд шинээр тодорхойлж болно.

⁶ Эх сурвалж: Аймгийн ЗДТГ-ын 2021, 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтээс.

1	6.3.2 Хот, суурин газрын усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулж, усны нөөц бохирдож, хомсцохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал 20,7 сая төгрөгөөр Цогт сумын Төгрөг гол, Цээл сумын Цээл гол, Чандмань сумын Хүрхрээ голд усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох, тэмдэгжүүлэх ажлыг “Премиум эко” ХХК-тай гэрээ байгуулан ажлын даалгаврын хүрээнд доорх ажлуудыг гүйцэтгүүлэн хүлээн авч тухайн сумдын өмч хөрөнгөнд бүртгүүлэн, цаашдын арчилгаа хамгаалалтыг хариуцуулсан Тус ажлын хүрээнд 3 голын 5625м2 талбай хамгаалагдаж, нөлөөлөлд өртдөг 12 газарт мэдээллийн самбар байршуулсан.	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 42.6 сая төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 15.0 сая төгрөг нийт 57.6 сая төгрөгөөр Төгрөг, Эрдэнэ, Дарив сумдын 3 голын гадны нөлөөлөлд өртөж буй хэсгүүдэд усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоон 1067 м тороор хашаа хамгаалалт хийж, 12 ширхэг тэмдэгжүүлэлтийн самбар байршуулан, гадны нөлөөлөлд өртдөг 12 хэсэг газарт загон татах ажлыг “Ком-Алтай” ХХК-аар гүйцэтгүүлж байна.
2	6.3.3 Хөрсний үржил шим, чийгийг ойн зурвас, хөв цөөрөм байгуулах, булаг шандын эхийг хаших замаар хамгаална.		Шарга сумд 2, Баян-Уул сумд 4, Есөнбулаг сумд 3, Жаргалан, Цогт, Эрдэнэ, Чандмань, Халиун сумдад тус бүр 1 булгийн эхийг хашсанаар нийт 19414 булаг хамгаалагдсан байна. Тус ажилд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал 14.5 сая төгрөг, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 104.6 сая төгрөг, ААН-ийн санхүүжилтээр 22.0 сая төгрөг нийт 141.1 сая төгрөг зарцуулагдсан байна.

Эх сурвалж: Аудитын ажлын баримтаас

А1.2.4. “Говь-Алтай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд “Ногоон хөгжлийн бодлого” Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд 9 зорилтын 26 арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна. Үүнээс БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтийн тухайд 2021 онд 3 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг үр дүнтэй, 2022 онд 3 зорилтын 3 арга хэмжээг 90 хувьтай хэрэгжүүлжээ.

Хүснэгт-3 Говь-Алтай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилт

№	Арга хэмжээ	Хэрэгжилт	
		2021	2022
1	5.1.1. Хүн амын усан хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуулын ажлыг хийж, нөөцийг тогтоон, бохирдож, хомсцохоос сэргийлж, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэн ундны усны чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангах бодлогыг олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 20.8 сая төгрөгөөр Цогт сумын Төгрөг гол, Цээл сумын Цээл гол, Чандмань сумын Хүрхрээ голд усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох, тэмдэгжүүлэх ажлыг “Премиум эко” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлээ. Үүний үр дүнд дээрх 3 голын 5625 м2 талбай хамгаалагдаж байгаа бөгөөд нөлөөлөлд өртдөг 12 газарт мэдээллийн самбар байршуулсан.	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 42.6 сая, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 15.0 сая, нийт 57.6 сая төгрөгөөр Төгрөг, Эрдэнэ, Дарив сумдын 3 голын гадны нөлөөлөлд өртөж буй хэсгүүдэд усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоон 1067 м тороор хашаа хамгаалалт хийж, 12 ширхэг тэмдэгжүүлэлтийн самбар байршуулан, гадны нөлөөлөлд өртдөг 12 хэсэг газарт загон татах ажлыг “Ком-Алтай” ХХК-аар гүйцэтгүүлж байна.
2	5.1.2. Хөрсний үржил шим, чийгийг ойн зурвас, хөв цөөрөм байгуулах, булаг шандын эхийг хаших замаар хамгаалж,	Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газрын 173.0 сая төгрөгөөр Дарив, Төгрөг, Баян-Уул сумдад нийт 6 булгийн эхийг, “Монголын унаган байгалийн	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 14.5 сая төгрөгөөр Баян-Уул, Есөнбулаг, Шарга сумдад 3 булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг “Тангууд” ХХК-аар

	газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээнэ.	хүлцэл, тогтворжилтыг хангах нь” төслийн 33.0 сая төгрөгөөр Чандмань, Цогт, Эрдэнэ сумдад нийт 4 булгийн эхийг, бичил төслийн 12.0 сая төгрөгөөр 3 булгийн эхийг, хувийн 3.0 сая төгрөгөөр 1 булгийн эхийг, нийт 221.0 сая төгрөгөөр 14 булгийн эхийг хашиж хамгааллаа. Мөн уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Алтайн хүдэр”, “Болд Гянт Болд, “Гобикоулд энд инерж” ХХК-уудын 23.5 сая төгрөгөөр Цээл сумын Сүүж, Есөнбулаг сумын Адгийн гол, Чандмань сумын Бор өргөтийн булгийг хашиж хамгааллаа. Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд нийт 17 булгийн 12.8 га талбайг хамгаалж, 244.5 сая төгрөг зарцуулсан.	гүйцэтгүүлж, хүлээн авлаа. Дэлхийн байгаль хамгаалах сангийн санхүүжилт 12.5 сая төгрөгөөр Халиун сумд 1 булаг, Ирвэстэй нутгийн ирээдүй төслийн санхүүжилт 71.0 сая төгрөгөөр Шарга сумд 1, Баян-Уул сумд 3, Жаргалан сумд 2, нийт 7 булаг хашиж хамгаалах ажлыг “Хасагтын гоёл” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, хүлээн авлаа. 2022 онд нийт 10 булгийн эхийг хашиж хамгаалах ажилд орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар нийт 98.0 сая төгрөг зарцуулагдсан байна. Булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэснээр усны ундарга чөлөөлөгдөж, иргэдийн ундны усны эрүүл ахуйн нөхцөл сайжирсан.
3	5.1.3. Монгол бөхөн, тарвага, Халиун бугыг сэргээн нутагшуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Төв аймгийн Хустайн нуруунаас 10 толгой Халиун бугын илийг 06 дугаар сарын 29-ний өдөр “Алтайн халиун буга” ТББ-тай хамтран Хантайширын нуруунд нутагшуулах ажлыг зохион байгуулж, тус ТББ-аас 10.0 сая төгрөг зарцууллаа. Бугын илийг тэжээх, арчлахад шаардлагатай сүү, 200 боодол өвсийг шийдвэрлэж, орон нутгийн төсвөөс 3.9 сая төгрөг зарцуулсан.	Хустайн нуруунаас бугын төл 50 илийг авчирч, Хантайширын нуруунд гаршуулан тэжээж 35 илийг байгальд нь зэрлэгшүүлж нутагшуулах ажлыг хэрэгжүүлж байна. 2022 онд 1 настай 10 бугад сансрын дохиололтой хүзүүвч зүүн, байгальд нь гаргаж зэрлэгшүүлэх, зайн тандалт судалгаа, ажиглалт хийгдэж байна. Жил бүр байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 100-200 боодол өвсийг зарцуулж, биотехникийн арга хэмжээ авч дэмжиж ажилласан.

Эх сурвалж: Аудитын ажлын баримтаас

А1.2.5. Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны төлөвлөгөөний 5 дугаар бүлэгт “Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх” зорилтын хүрээнд 2022 онд 6 арга хэмжээг 975.1 сая төгрөгийн, 2023 онд 13 арга хэмжээг 665.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хэрэгжүүлэхээр ногоон хөгжлийн бодлогыг тусгасан байна.

Үүнээс БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтийн тухайд 2022 онд 1 арга хэмжээг тусгаж 70 хувьтай хэрэгжүүлсэн.

Хүснэгт-4 Аймгийн хөгжлийн 2022, 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилт

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлсэн байдал
1	Усны сан бүхий газарт онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх 2022 үүсвэрүүдэд эрүүл ахуйн бүс тогтоож, тэмдэгжүүлэн, загон татаж, дэглэмийг мөрдүүлэх	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 42.6 сая, сумын орон нутгийн хөгжлийн сангийн 15.0 сая, нийт 57.6 сая төгрөгөөр Төгрөг, Эрдэнэ, Дарив сумдын 3 голын гаднын нөлөөлөлд өртөж буй 2д хэсгүүдэд усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоон 1067 м тороор хашаа хамгаалалт хийж, 12 ширхэг тэмдэгжүүлэлтийн самбар байршуулан, гаднын нөлөөлөлд өртдөг 12 хэсэг газарт загон татах ажлыг “Ком-Алтай” ХХК- аар гүйцэтгүүлж байна

Эх сурвалж: Аудитын ажлын баримтаас

Харин 2023 онд Аялал жуулчлалын бүс дагуух гол, нуурын нөлөөлөлд өртөж буй хэсгүүдэд тэмдэгжүүлэлтийн самбар, байршуулан дэглэм мөрдүүлэх, Нэн ховор, ховор амьтны усан хангамжийг сайжруулах зорилгоор булаг шандын эхийг хашиж хамгаалах (Хөхморьт, Төгрөг, Бугат сумд), Дотоодын амрагч, аялагчид ихээр зорин очиж буй Тайшир сумын Завхан гол, Шарга сумын Талын хүрхрээ зэрэг нөлөөлөлд өртөж буй усны сан бүхий газруудад стандартын шаардлагад нийцсэн хогийн сав, эко ариун цэврийн байгууламж хийж байршуулах зэрэг арга хэмжээг төлөвлөсөн ба хэрэгжилт тайлагнах хугацаа болоогүй байна.

A1.3. Ойн болон тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн менежментийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлээгүй байна.

A1.3.1. Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу аймгийн Засаг дарга нь ой бүхий сумын ойн менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавихаар заасан.⁷

Говь-Алтай аймгийн Жаргалан, Тайшир, Есөнбулаг Шарга, Халиун сумдын нутагт хэсэг, төгөл хэлбэрээр ургасан шинэсэн болон улиасан ой, Алтай, Бугат, Бигэр, Цогт, Шарга, Цээл, Төгрөг, Халиун, Эрдэнэ, Тонхил зэрэг 10 сумын нутгаар заг ургасан байна. Бага хэмжээний талбайд тоорой, сухай, хармаг ургасан боловч "ойн менежментийн төлөвлөгөө"⁸-г дээрх сумууд нь аймгийн Засаг даргаар батлуулаагүй байна.

Байгаль орчны Сайдын 1996 оны 230 дугаар тогтоолоор ойн санг 4 бүс болгон хувааснаас Говь-Алтай аймгийн ой нь 1-р бүсэд багтдаг. Энэ бүсийн ойд зөвхөн арчилгаа цэвэрлэгээний огтлолт, ойжуулалт, ойг нөхөн сэргээх арга хэмжээний үйл ажиллагаа явуулдаг.

A1.3.2. Аймгийн хэмжээнд ойн менежментийн төлөвлөгөө батлуулан үйл ажиллагаа явуулж буй иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага байхгүй байна.

Ой бүхий аймаг, сумын ойн менежментийн төлөвлөгөөг 2022 оны ойн зохион байгуулалтын ажлын тайлан Ойн газарт хянагдаж байгаа тул тус төлөвлөгөөг батлуулаагүй. Заган ойн зохион байгуулалтын ажлыг 2011 онд 10 сумд хийж гүйцэтгэсэн байна.

Хүснэгт-5 Ойн зохион байгуулалтын ажлын тайлан					
ДД	Нэр	Ойн зохион байгуулалтын ажлын тайлан		Тайлбар	2022 онд хийгдсэн Ойн газар хянагдаж байгаа
		заган ой	шинэсэн ой		
		2011	2016		
1	Алтай сум	+			+
2	Баян-Уул сум			ой байхгүй	
3	Бигэр сум	+			+
4	Бугат сум	+			+
5	Дарив сум			ой байхгүй	
6	Дэлгэр сум			ой байхгүй	
7	Жаргалан сум		+		
8	Тайшир сум		+		
9	Тонхил сум	+			+
10	Төгрөг сум	+			+
11	Халиун сум	+	+		+
12	Хөхморьт сум			ой байхгүй	

⁷ 17.2.10.ой бүхий сум, дүүргийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

⁸ 3.1.6."ойн менежментийн төлөвлөгөө" гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх, эсхүл эзэмшлийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт бичгийг;

13	Цогт сум	+			+
14	Цээл сум	+			+
15	Чандмань сум			ой байхгүй	
16	Шарга сум	+	+		+
17	Эрдэнэ сум	+			+
18	Есөнбулаг сум		+		
	Нийт	10	5		10

Эх сурвалж: Аудитын ажлын баримтаас

А1.3.2. Усны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу “усны сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө”⁹-г сав газрын захиргаа, усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага боловсруулан байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар заасан.¹⁰

Аймгийн нутаг дэвсгэрт “Хүйсийн говь-цэцэг нуурын сав газрын захиргаа” үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн А/1280 дугаар тушаалын хавсралтаар усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг 2 үе шаттайгаар 85 арга хэмжээг 59,487.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хэрэгжүүлэхээр баталжээ. Тус газрын төлөвлөгөөний биелэлтээ жил бүр холбогдох байгууллагуудад тайлагнаж байгаа бөгөөд аудитаар давтан тооцоход 2020 онд 40.8 хувь, 2021 онд 69.4 хувь, 2022 онд 72.9 хувьтай хэрэгжүүлсэн байна.

А1.3.3. Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.7-т “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь агнуурын нөөц бүхий аймаг болон ангийн аж ахуйн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг¹¹ батлах, хэрэгжилтэд хяналт тавих”-аар тусгасан.

Говь-Алтай аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг 2019-2024 онд 46 арга хэмжээг 152.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталжээ. Харин ангийн аж ахуйн агнуурын менежментийн төлөвлөгөөг 2 аж ахуйн нэгж батлуулжээ.

Хүснэгт-6 Ан агнуурын менежментийн төлөвлөгөө

№	Нэр	Баталсан шийдвэр	Хугацаа	Арга хэмжээ	Төсөвт өртөг	2021 онд дэвшүүлсэн зорилт			2022 онд дэвшүүлсэн зорилт			2023 онд дэвшүүлсэн зорилт
						Нийт	Хэрэгжүүлсэн	Хэрэгжилтийн хувь	Нийт	Хэрэгжүүлсэн	Хэрэгжилтийн хувь	
1	Монгол тур ХХК-Алтай сум	Алтай сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.04.15 №15 дугаар тогтоол	2020-2024	56	32.7	20	0	0	28	0	0	28
2	Натурал Ай Эн Эй ХХК-Бугат сум	Бугат сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.12.09 №09 дугаар тогтоол	2019-2024	78	45.5	65	0	0	36	0	0	21

⁹ 3.1.16."усны нөөцийн менежментийн төлөвлөгөө" гэж сав газрын усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохицуулах баримт бичгийг;

¹⁰ 4.7.Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь усны сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө /цаашид "сав газрын менежментийн төлөвлөгөө" гэх/-г энэ хуулийн 4.4-т заасан ашиглах боломжит нөөцийн хэмжээг үндэслэн боловсруулна.

4.8.Сав газрын менежментийн төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

¹¹ 4.1.11."ан агнуурын менежментийн төлөвлөгөө" гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичгийг;

3	Тийм.Натурал Ай Эн Эй ХХК- Жаргалан сум	Жаргалан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.04.23 №14 дугаар тогтоол	2019- 2024	78	45.5	65	6	9%	36	0	0	21
4	Тийм.Натурал Ай Эн Эй ХХК- Цогт сум	Цогт сумын ИТХ- ын Тэргүүлэгчдийн 2020.05.19 №17 дугаар тогтоол	2019- 2024	78	45.5	65	3	5%	36	0	0	21

Эх сурвалж: Аудитын ажлын баримтаас

Ангийн аж ахуйн ан агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу 2021-2022 оны гүйцэтгэл 5-9 хувийн гүйцэтгэлтэй байна.

А1.3.4. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Засаг дарга нь хамгаалалтын захиргаа, зөвлөлтэй хамтран энэ хуульд заасны дагуу орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ” гэж заасан. Говь-Алтай аймгийн хувьд орчны бүсийн менежментийн төлөвлөгөө баталж хэрэгжүүлээгүй байна.

Түүнчлэн Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 6¹ дугаар зүйлд¹² орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг менежментийн төлөвлөгөөтэй байж болохоор тусгасан бөгөөд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар батлагдаагүй байна.

А2. БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахын тулд эрх бүхий албан тушаалтны хамтран ажиллах гэрээнд тухайн жилийн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээ, зарцуулах төсвийг шалгуур үзүүлэлт бүрээр тусган хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллах шаардлагатай байна.

А2.1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нь байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг хамтран ажиллах гэрээнд тусган дүгнэж байна.

А2.1.1. Монгол Улсын Засгийн газрын “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” батлах тухай 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг удирдлага болгон, 2021, 2022 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай хамтран ажиллах гэрээ байгуулсан 21 аймаг, нийслэлийн Засаг даргаас ирүүлсэн гэрээний үүргийн биелэлтэд үнэлэлт, дүгнэлт өгсөн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан Говь-Алтай аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээний биелэлтийг үзэхэд 2021 онд 62 арга, хэмжээг 81.1 хувь, 2022 онд 57 арга хэмжээг 81.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

А2.1.2. Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 4.8-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээ, зарцуулах төсвийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хийх гэрээнд шалгуур үзүүлэлт бүрээр тусгана” гэж заасан.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулсан Говь-Алтай аймгийн Засаг дарга нарын хамтран ажиллах гэрээнд тусгагдсан арга хэмжээнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан байдлыг авч үзэхэд 2021, 2022 онд 4 арга, хэмжээг 80 хувийн биелэлттэй тус тус хэрэгжүүлжээ.

¹² 5.Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг менежментийн төлөвлөгөөтэй байж болох бөгөөд төлөвлөгөөг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

Түүнчлэн 2021 оны гэрээний 1.7-т “БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах”, 2022 оны гэрээний 1.7-т “БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтийг аймаг, сумын түвшинд хангах, хуулийн дагуу зарцуулах” гэж заасан нь хуулийн хэрэгжилтийг хангахад ихээхэн нөлөөтэй байна. Мөн 2023 онд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээг байгуулжээ.

А2.1.3. Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргаатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг авч үзэхэд 2021 онд 41 арга хэмжээг 96 хувьтай, 47 арга хэмжээг 85.9 хувьтай хэрэгжүүлжээ. Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан байдлыг авч үзэхэд 2021 онд 3 арга хэмжээг 80 хувьтай, 2022 онд 5 арга хэмжээг 68 хувьтай тус тус хэрэгжүүлжээ.

А2.1.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах гэрээний үүргийн биелэлтийг ажлын хэсгээс дүгнэж, жилийн гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийж, дараах дүгнэлтийг хүргүүлсэн байна. Тухайлбал:

- ✓ *Хамтран ажиллах гэрээний зорилт арга хэмжээ болон хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг оновчтой төлөвлөөгүй, хамтран ажиллах гэрээнд мэдээ тайлан ирүүлэх, сургалт зохион байгуулах зэрэг шаардлагагүй арга хэмжээ төлөвлөсөн.*
- ✓ *Гэрээнд тусгасан арга хэмжээний биелэлтийг оновчтой, товч тодорхой нотлогдохуйц бичээгүй, хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хүрэх үр дүн тодорхойгүйгээс зорилтот түвшинд хүрээгүй, төлөвлөлтөө ойлгоогүйгээс биелэлтийг зөрүүтэй тайлагнасан, үр дүнг бус үйл явц, мэдээлэл бичсэн, зарим арга хэмжээний биелэлтийг бичиж ирүүлээгүй орхигдуулсан.*
- ✓ *Гэрээнд тусгагдсан 9 зорилтын хүрээнд аймаг бүр 38-77 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан, зорилт арга хэмжээг оновчтой тодорхойлоогүй, арга хэмжээний хүрэх үр дүнг тоо чанарын үзүүлэлтээр тодорхойлоогүй, нэг зорилтын дор агуулга давхардсан арга хэмжээг ажил болгож оруулсан гэрээнд тусгагдсан арга хэмжээг огт тайлагнаагүй, үр дүнг өмнөх түвшинтэй харьцуулж дүгнээгүй, давхардуулан тайлагнасан.*

Цаашид Байгаль орчин, аялал жуулчлалын сайдтай байгуулах гэрээнд “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг гүйцэтгэлийн талаар гэрээний биелэлтэд мөнгөн дүн болон хувиар илэрхийлэн, хүрэх үр дүнг тодорхой тусгах шаардлагатай байна.

А2.2. Аймгийн Засаг дарга сумдын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний байгаль орчны чиглэлээр дэвшүүлсэн зорилтдоо байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцаатай холбоотой арга, хэмжээг тусгаагүй.

А2.2.1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйл, 59 дүгээр зүйлийн 59.1.8 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2, 39.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 37, 38 дугаар зүйлийг үндэслэн нэг талаас аймгийн Засаг дарга, нөгөө талаас сумдын Засаг дарга нарын 2021, 2022 онд хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан байна.

Хамтран ажиллах гэрээний зорилго нь сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, “Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”, “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, орон нутгийн тэгш хөгжлийг хангахад дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэх, үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах, хамтран ажиллах, талуудын эрх үүрэг, хүрэх дүнг тодорхойлох, хэрэгжилтийг дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийг авч үзвэл 2021 онд 1647 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж 77.8 хувьтай, 2022 онд 2439 арга хэмжээг

хэрэгжүүлэхээр баталж 78.8 хувьтай дүгнэсэн байна. Харин 2023 онд 2287 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ.

Хүснэгт-7 Аймгийн Засаг дарга сумын Засаг дарга, харьяа төсөв захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн гэрээний хэрэгжилт

№	Нэр	2021 он					2022 он					2023 он	
		Дундаж үнэлгээ		Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан			Дундаж үнэлгээ		Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан			Тоо	Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан
		Тоо	%	Тоо	дүгнэсэн%	аудитаар %	Тоо	%	Тоо	дүгнэсэн %	аудитаар %		
1	Алтай сум	91	83.0	3	63.3	50.0	138	88.70	4	82.5	82.5	171.0	4
2	Баян-Уул сум	87	81.8	0			69	79.80	7	95.71	95.7	68.0	12
3	Бигэр сум	90	77.7	0			141	69.20	0			170.0	1
4	Бугат сум	89	79.3	0			139	77.50	1			171.0	2
5	Дарив сум	91	80.8	0			143	67.80	1	70	0.0	171.0	1
6	Дэлгэр сум /Гуулин	89	75.3	0			141	76.80	0				
7	Жаргалан сум	91	82.5	1	90	50.0	147	75.50	4	70	70.0	170.0	1
8	Тайшир сум	91	79.2	0			143	69.90	1	30	0.0	169.0	1
9	Тонхил сум	89	86.7	1	100	100.0	125	83.30	1				2
10	Төгрөг сум	91	76.0	0			138	75.20	1	100	100.0		
11	Халиун сум	92	76.8	0			127	79.90	3	96.7	96.7	174.0	4
12	Хөхморьт сум	90	77.7	3	90	80.0	136	73.10	4	65	57.5	165.0	4
13	Цогт сум	90	80.2	2	100	50.0	142	90.20	2	100	75.0	172.0	2
14	Цээл сум	91	75.3	1	100	100.0	147	85.00	1	70	70.0		2
15	Чандмань сум	95	74.0	1			144	77.60	1	30	20.0	170.0	1
16	Шарга сум	91	75.3	1	90		147	85.00	1	70	0.0	170.0	1
17	Эрдэнэ сум	95	69.2	1	62	62.0	138	87.10	1	100	100.0	169.0	0
18	Есөнбулаг сум	104	68.8	0			134	77.90	0	0	0.0	177.0	2
	Сумын дүн	1647	77.8	14	86.9	70.3	2439	78.9	33	70.0	54.8	2287	40
19	БОАЖГ	81	77.7	6	100	93.0	105	91.23	13	93.8	92.3	105.0	8
20	Ойн анги	29	86.9	1	70	70.0	27	88.21	1	30	30.0	25.0	0
	Харьяа байгууллага	110	82.3	7	85.0	81.5	132	89.7	14	61.9	61.2	130	8
	Дундаж үнэлгээ	1757	80.0	21	86.0	75.9	2571	84.3	47	65.9	58.0	2417	48

Эх сурвалж: Говь-Алтай аймаг дахь Аудитын газрын ажлын баримтаас

A2.2.2. Сумын Засаг дарга тухайн жилийн байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээ, зарцуулах төсвийг аймгийн Засаг даргатай хийх гэрээнд шалгуур үзүүлэлт бүрээр тусгасан эсэхийг аудитаар тулган баталгаажууллаа. Үүнд:

- ✓ 2021 онд Баян-Уул, Бигэр, Бугат, Дарив, Дэлгэр, Тайшир, Төгрөг, Халиун, Чандмань, Есөнбулаг сум, 2022 онд Бигэр, Бугат сум, 2023 онд Дэлгэр, Төгрөг сум нь байгаль орчны чиглэлээр дэвшүүлсэн зорилтдоо байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцаатай холбоотой арга, хэмжээг тусгаагүй.
- ✓ 2021 онд Алтай, Жаргалан, Хөхморьт, Цогт, Шарга сумын, 2022 онд Дарив, Тайшир, Хөхморьт, Чандмань, Шарга сумын байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан арга, хэмжээний хэрэгжилтийг аудитаар давтан хянаж үзэхэд биелэлтийн хувийг илүү өндрөөр үнэлсэн байна.

A2.2.3. Аймгийн Засаг дарга БОАЖГ-ын даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг авч үзэхэд 2021 онд 81 арга хэмжээг 77.7 хувьтай, 105 арга хэмжээг 91.23 хувьтай хэрэгжүүлжээ. Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан байдлыг авч үзэхэд 2021 онд 6 арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж, 2022 онд 13 арга хэмжээг 93.8 хувьтай тус тус хэрэгжүүлжээ.

Харин аймгийн Засаг дарга Сум дундын ойн ангийн даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг авч үзэхэд 2021 онд 29 арга хэмжээг 86.9 хувьтай, 27 арга хэмжээг 88.21 хувьтай хэрэгжүүлжээ. Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан байдлыг авч үзэхэд 2021 онд 1 арга хэмжээг 70 хувьтай, 2022 онд 1 арга хэмжээг 30 хувьтай тус тус хэрэгжүүлжээ.

БҮЛЭГ Б. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ХЭСГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

Б1. Байгалийн нөөцийг бүрэн тогтоогоогүй байхад ашиглах шийдвэр олгож, төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журмын дагуу хэрэгжүүлээгүй байна.

Б1.1. Аймгийн хэмжээний усны болон ургамлын нөөцийг тогтоогоогүй байна.

Б1.1.1. Усны нөөцийг бүрэн тогтоогоогүй байна. Зөвлөлт Холбоот Улсын (хуучин нэрээр) мэргэжилтнүүдийн тусламжтайгаар 1971-1975 онд монгол орны нийт усны нөөцийг 608,29 шоо км гэж тогтоосон бөгөөд үүнээс гол мөрөн 34,6 шоо км, нуур тойром 500,0 шоо км, мөнх цас, мөсөн гол 62,9 шоо км, газрын доорх ус 10,79 шоо км гэж тогтоожээ. Усны нийт нөөцөөс ашиглаж болох боломжит нөөц нь 15,75 шоо км бөгөөд үүнээс 4,96 шоо км нь гадаргын ус, үлдсэн нь газрын доорх ус байна.

Үүнээс хойш усны нөөцийг дахин тогтоогоогүй бөгөөд энэ хугацаанд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, дулаарал, уул уурхайн үйлдвэрлэл, хүн амын усны хэрэглээний өсөлт, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн зүй бус ашиглалт зэргээс шалтгаалан усны нөөц өөрчлөгдсөн байх магадлал их юм.

УСНЫ НӨӨЦ



Б1.1.2. Ус хангамжийн эх үүсвэрийн судалгаа Алтай хотын усан хангамжийн системийг сайжруулах, гүний усны нөөцийг өргөжүүлэх, гэр хорооллыг, хүн амыг хямд усаар хангах чиглэлээр Япон улсын Засгийн газрын санхүүжилтээр 1999 онд хийгдсэн “ЖАЙКА” төслийн судалгаагаар Харзат, Олон нуур, Сүхийн хоолой, Хадаасан, Алтай хотын зүүн хойд хэсэг, Цагаан тохойн, Тайширын эх үүсвэрийн газрын доорх усыг ашиглах хувилбараар судалгаа хийсэн байна.

Хүснэгт-8. Судалгааны талбайд хамрагдсан эх үүсвэрүүдийн ашиглах боломж

Эх үүсвэрийн нэр	Ашиглах боломж	Усны чанар	Хатуулаг (CaCO ₃), л	Тэргүүлэх боломж
Харзатын эх үүсвэр	Өргөжүүлэх боломжтой	Сайн	225	1
Олон нуурын эх үүсвэр	Ашиглах боломжтой	Сайн	256	2
Сүхийн хоолой	Усны чанар муу	Муу		
Хадаасан	Хангалттай нөөцтэй	Дунд	363	
Алтай хотын зүүн хойд хэсгийн эх үүсвэр	Усны нөөц дунд зэрэг	Муу	1875	
Цагаан толгойн эх үүсвэр	Хангалттай нөөцтэй, усны чанар боломжтой боловч хол зайтай	Сайн	406	
Тайшираас Завхан голын усыг ашиглах	Хангалттай нөөцтэй, гэвч хол зайтай	сайн		

Эх сурвалж: Говь-Алтай аймаг дахь Аудитын газрын ажлын баримтаас

“ЖАЙКА” байгууллагын тайланд “Одоо ашиглаж байгаа Харзатын эх үүсвэр нь 2015 онд усны нэмэгдсэн хэрэглээг хангахуйц нөөцтэй. Энэ нь Алтай хотод ойрхноос гадна үлдсэн газрын доорх усыг зөв хамгаалж зүй зохистой ашиглавал нөөц нь хангалттай байгаа” гэж дурдсан байна. Дээрх судалгааны ажлаар 600 км² талбайг хамарсан хайгуул, судалгааны ажил хийгдсэн боловч одоо ашиглаж байгаа Харзат, шинээр ашиглах боломжтой Олон нуурын эх үүсвэрийн усны нөөцийг баталгаажуулаагүй байна.

Б1.1.3. Цогт сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх эрэл хайгуул, судалгааны ажлыг 2019 онд “Охь-Ус” ХХК гүйцэтгэжээ. Байгаль, орчин, аялал, жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн даргын “Усны нөөц батлах тухай” А/271 дугаар тушаалын 1.2-т “Говь-Алтай аймгийн Цогт сумын төвийн хүн амын ус

хангамжийн эх үүсвэрийн газрын доорх усны ашиглалт хайгуул судалгааны ажлын үр дүнгээр тогтоогдсон газрын доорх усны “Төгрөгийн гол”-ийн ордны нөөцийг үйлдвэрлэлийн С зэргээр нийт 13.0 л/с буюу 1123.3 м3/хоногоор баталсугай” гэжээ.

Б1.1.4. Говь-Алтай аймгийн усны нөөцийг өнөөгийн байдлаар бодитой тогтоох нь усны талаар баримтлах төрийн бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ашиглаж болох усны нөөцийн хэмжээг үндэслэн усны сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, гадаргын болон газрын доорх уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаарыг усны сав газар бүрээр байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоохоор хуульчилсан.

Усны нөөц ямар байгааг тогтоогоогүй байхад ус ашиглах зөвшөөрөл олгосон болон зөвшөөрөлгүй ус ашиглагч нарын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахгүй байгаа нь усны хомсдолд орох нөхцөл бий болох эрсдэлтэй. Усны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Энэ хуулийн 4.4-т заасан усны нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг тогтоох хайгуул, судалгааны ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэнэ” гэж заасан. Гэвч хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүйн улмаас аймгийн хэмжээний усны нөөцийг тогтоох боломжгүй байсаар иржээ.

Б1.1.5. Ан амьтны нөөц: Амьтны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ агнуур зохион байгуулалтыг таван жил тутамд хийлгэж, үйлдвэрлэлийн зориулалтаар агналт явуулсан тохиолдолд жил бүр тооллого хийнэ”, мөн хуулийн 21-р зүйлийн 4 дэх хэсгийн “Агнуурын нөөцийг хамгаалах зорилго бүхий мэргэжлийн байгууллага нь агнуурын нөөц, түүний тооллого бүртгэл, агнуур зохион байгуулалтын ажлыг улс, орон нутгийн болон иргэн, хуулийн этгээдийн захиалга, хөрөнгөөр гүйцэтгэх, тэдгээрийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулах”, 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Агнуур зохион байгуулалтыг төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ” зэрэг хууль эрхзүйн заалтуудыг үндэслэл болгон Говь-Алтай аймгийн БОАЖГ-ын захиалга, санхүүжилтээр байгаль орчны мэргэжлийн байгууллага “Авралын Эрэлд” ХХК ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааны ажлыг гүйцэтгэх ГAA201906006 тоот гэрээг байгуулан, тус аймгийн нутаг дэвсгэрийг бүрэн хамруулан анхдагч мэдээ хэрэглэхүүн бүрдүүлэх хээрийн судалгааг гүйцэтгэсэн байна.

Аймгийн 2019 оны ерөнхий агнуур зохион байгуулалтаар 603 км² нутагт 284±25 толгой аргаль хонь, 9078.2 км² нутагт 3566±108 толгой янгир ямаа, 2381 км² нутагт 450±76 толгой халиун буга байна. Идлэг шонхор шувууны нөөцийг тогтоогоогүй байна.

Б1.1.6. Ойн нөөц: Монгол орны заган ойн талбайг анх 1956 онд ЗХУ-ын техник мэргэжилтний тусламжтайгаар 1:100000-ны масштабтай байр зүйн зургаар заган ойн тархалтыг тогтоосон. Үүнээс хойш 1975 онд ой зохион байгуулах замын экспедиц заган ойд газрын нарийвчилсан судалгааг явуулж 3.8 сая га гэж тогтоосон байна. 1990 онд улсын хэмжээнд заган ой тархсан бүх нутаг дэвсгэрийг хамарсан газрын нарийвчилсан судалгааг давтан хийж заган ойг 4.5 сая га талбайг хамарч байгааг тогтоосон.

Говь-Алтай аймгийн хувьд хамгийн сүүлд 1990 онд аймгийн хэмжээгээр заган ойн тооллого бүртгэл, ой зохион байгуулалтын ажлыг хийж 1,925,655 га талбайд тархан ургаж байна хэмээн тодорхойлжээ. Түүнээс хойш Говь-Алтай аймгийн хэмжээгээр заган ойн судалгааны ажил хийгдээгүй бөгөөд зарим нэг төсөл хөтөлбөрийн хүрээнд тоорой модыг судалсан.

Монгол Улсын “Ойн тухай” хуулийн 6-р зүйлийн “Ойн сангийн нөөцийг шинэчлэн тогтоох ой зохион байгуулалтыг 10 жил тутам давтан хийнэ” гэсэн гурав дахь заалт, “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хууль”-ийн дагуу Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас зарласан Говь-Алтай Алтай,

Бигэр, Бугат, Тонхил, Төгрөг, Халиун, Цогт, Цээл, Шарга, Эрдэнэ сумдын заган ойд ой зохион байгуулалтын ажлыг 2022 онд хийсэн уг ажлын тайлан Ойн газар хянагдаж байна.

Б1.1.7. Байгалийн ургамлын нөөц: Говь-Алтай аймгийн хэмжээнд нэн ховор, ховор, ашигт ургамлын судалгааны ажлыг 2014-2015 онд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн. Аймгийн хэмжээнд ургаж байгаа ургамлын тархац нөөцийн иж бүрэн судалгааны ажил хийгдээгүй байна.

Б1.1.8. Байгаль орчин аялал жуулчлалын сайд Говь-Алтай аймгийн байгалийн нөөц ашиглах дээд хязгаарыг 2021-2022 онд доорх үзүүлэлтээр баталсан байна. Үүнд:

- ✓ Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/217 дугаартай тушаалаар 800м3 шинэс модыг цэвэрлэгээний ажлаар бэлтгэх дээд хязгаарыг баталж өгсөн байна.
- ✓ Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар Говь-Алтай аймагт 2021-2023 онуудад тусгай зориулалтаар 26 тэх, 4 буга, ахуйн зориулалтаар 90 чоно, 3000 загас агнаж баруулахаар, мөн гадаадын иргэнд агнуулсан болон гадаад улсад амьдаар нь 10 шонхор шувууг агнах зөвшөөрөл олгосон.
- ✓ Хүн амын унд, ахуйн болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуйн зориулалтаар давхардсан тоогоор 71 хуулийн этгээд ус ашигласан байна.

Байгалийн нөөцийг бүрэн тогтоогоогүй байхад ашиглах зөвшөөрөл олгож байгаа нь үндэслэлгүй байна.

Б1.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журамд заасан цаглаварт хугацаанд хэрэгжүүлээгүй байна.

Б1.2.1. Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам” баталснаар Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоол хүчингүй болгосон байна.

Энэ журмын зорилго нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт БНАТ-ийн тухай хуулийн 13.1-д заасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг (цаашид “төлбөрийн орлогын хэсэг” гэх) байгалийн ургамал, ан амьтан, газар, ус, рашаан, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос бүрдүүлэх, төсвийн суурь зарлагад байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг тусгах, зарцуулах, тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Б1.2.2. Төсвийн жилийн төлбөрийн орлогын хэсгийг энэ журмын 1.2-т заасан орлогоос БНАТ-ийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээ болон түүнээс дээш хэмжээгээр бүрдүүлэхээр байна. Аймгийн Засаг дарга нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээний талаарх саналаа жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхээр заасан боловч 2022 оны тухайд цаглаварт хугацаанд хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ИТХ ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор сум тус бүрээр тогтоогоогүй. Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 46 дугаар тогтоолоор “2022 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг” тогтоосон байна.

Б1.3. Усыг дүгнэлтгүй, зөвшөөрөлгүй, гэрээ байгуулалгүй, тоолуургүйгээр ашиглуулан, ан амьтан, ойн нөөц ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгосон байна.

Б1.3.1. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар Говь-Алтай аймагт 2021-2023 онуудад тусгай зориулалтаар 26 тэх, 4 буга, ахуйн зориулалтаар 90 чоно, 3000

загас агнаж бариулахаар, мөн гадаадын иргэнд агнуулсан болон гадаад улсад амьдаар нь 10 шонхор шувууг агнах зөвшөөрөл олгосон байна.

Хүснэгт-9 Ан амьтны нөөц ашиглах зөвшөөрөл, гүйцэтгэл /ширхэг/

Огноо	Зөвшөөрөл олгосон сумын тоо	Тусгай зориулалтаар агнах ан амьтан				Гадаадын иргэнд агнуулсан болон гадаад улсад амьдаар нь аливаа зориулалтаар гаргасан ан амьтан		Ахуйн зориулалтаар барих	Ахуйн зориулалтаар агнах
		Агнах зөвшөөрлийн тоо		Ашигласан тоо		Агнах зөвшөөрлийн тоо	Барьсан тоо толгой		
		Тэх	Буга	Тэх	Буга	Идлэг шонхор шувуу			
2021 он	6	15	2	2	1	4	4		
2022 он	6	11	2	12	2	6	6		
2023 он								3000	90
Дүн		26	4	14	3	10	10	3000	90

Эх сурвалж: Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаал /2020-2022 он/

Тусгай зориулалтаар 2021 онд 17 ан амьтан агнах зөвшөөрөл олгосон бөгөөд гүйцэтгэл 57 хувьтай байгаа нь ковид-19 цар тахал гарсантай холбоотой. Тусгай зөвшөөрлийн дагуу 10 идлэг шонхор шувууны агнуурын орлого нэр заасан сумын дансанд төвлөрсөн хэдий ч, агнуурыг хийхэд улсын байцаагч хяналт тавьдаггүй зөрчил байна.

Ахуйн зориулалтаар агнах чонын тухайд аймгийн ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 12 дугаартай тогтоолоор 18 сум тус бүрд 5 ширхэг чоно агнуулахаар тогтоол гарсан бөгөөд одоогоор гүйцэтгэл гараагүй байна.

Тайшир сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/04 дүгээр захирамжаар Гэгээн нуураас ахуйн зориулалтаар загас агнах, барих байршлыг тогтоож, сумын ИТХ-аас төлбөр хураах хэмжээг тогтоож өгсөн байна.

Б1.3.2. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2021 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн А/217 дугаартай тушаалаар 800м3 шинэс модыг цэвэрлэгээний ажлаар бэлтгэх дээд хязгаарыг баталж өгсөн байна.

Зөвшөөрлийн дагуу мод бэлтгэх сумын нэр, цэвэрлэгээ хийх талбай, бэлтгэх модны хэмжээг аймгийн ИТХ-ын 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 46 дугаар тогтоолоор баталсан. Ойгоос мод бэлтгэх дээд хязгаарыг мөрдөж ажилласан байна.

Хүснэгт-10 Ойгоос мод бэлтгэх дээд хэмжээ, гүйцэтгэл

Сумын нэр	Зөвшөөрөл		Гүйцэтгэлээр
	Иргэний тоо	Олгосон модны хэмжээ	
Жаргалан	15	200 м3	60м3
Халиун	3	400 м3	109м3
Есөнбулаг	4	200 м3	45 м3
Дүн	22	800 м3	214 м3

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Б1.3.3. Аймгийн хэмжээнд 2021 онд 23, 2022 онд 18 аж ахуйн нэгж, байгууллага ус ашиглах дүгнэлт гаргуулан ус ашигласан байна. Усны тухай хуулиар иргэн, ААНБ нь ус ашиглах хүсэлтээ энэ хуулийн 28.4-т заасан этгээдэд гаргаснаар ус ашиглах дүгнэлт, зөвшөөрлөө гаргуулж, гэрээ байгуулснаар ус ашиглах эрх үүсдэг.

Хүснэгт-11 Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ хийх эрх бүхий субъект

ДД	Хоногт ашиглах ус	Дүгнэлт гаргах эрх бүхий субъект	Зөвшөөрөл олгох эрх бүхий субъект	Гэрээ байгуулах эрх бүхий субъект
1	100 шоометрээс их	Усны газар	Сав газрын захиргаа	Сав газрын захиргаа
2	50-100 шоометр	Сав газрын захиргаа	Аймгийн БОАЖГ	Аймгийн БОАЖГ
3	50 шоометр хүртэлх	Аймгийн БОАЖГ	Сумын Засаг дарга	Сумын Засаг дарга

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Ус ашиглах дүгнэлтгүйгээр 2021 онд 17, 2022 онд 23 хуулийн этгээд үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ус ашигласан. Энэ нь 2021 оны нийт ус ашиглагчийн 42.5 хувийг, 2022 оны ус ашиглагчийн 56 хувийг эзэлж байна.


Ус ашиглуулах дүгнэлттэй боловч 2021 онд 12, 2022 онд 14 хуулийн этгээд сумын Засаг даргын зөвшөөрөлгүй, 2021 онд 14, 2022 онд 13 хуулийн этгээд гэрээ байгуулалгүйгээр ус ашигласан.

Усны тухай хуулиар ус ашиглагч ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах үүргийг хүлээдэг боловч усны тоолуургүйгээр 2021 онд 23, 2022 онд 29 хуулийн этгээд үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар ус ашигласан.

Аудитаар ус ашиглалтын төлбөрийг тоолуурын заалтаар тооцож төлсөн эсэхийг шалгахад “Алтайн хүдэр” ХХК, Болд гянт болд ХХК, “Хан-Алтай ресурс” ХХК, “Зост Өндөр” ХХК-ийн ус ашиглалтыг тоолуурын заалтаар төлбөр ногдуулсан, бусад ус ашиглагчдын тухайд дүгнэлтээр ус ашиглалтын төлбөрийг ногдуулжээ.

Б1.4. Байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулаагүй, төлбөрийн орлогын төлөвлөлт бодитой бус, ногдуулалт зөрүүтэй байна.

Б1.4.1. Аймгийн 2021 оны төсөвт ус, рашаан, ой, ургамал, амьтны нөөц ашигласны төлбөрт 623.8 сая төгрөгийн татварын орлого бүрдүүлэхээр төлөвлөж 581.6 сая төгрөг, 2022 оны төсөвт ус, рашаан, ой, ургамал, амьтны нөөц ашигласны төлбөрт 874.9 сая төгрөгийн татварын орлого бүрдүүлэхээр төлөвлөж 956.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.



Дээрх графикаас БНАТ-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг үзэхэд:

- ✓ 2021 онд унд ахуйн зориулалттай усны нөөц ашигласны төлбөрийн орлого 2.3 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 110.3 сая төгрөгөөр давж биелсэн, үйлдвэр үйлчилгээний зориулалттай усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 46.0 сая төгрөгөөр, газрын төлбөрийг 108.9 сая төгрөгөөр тасарсан.
- ✓ 2022 онд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2.2 сая төгрөгөөр, унд ахуйн зориулалттай усны нөөц ашигласны төлбөрийн орлого 5.3 сая төгрөгөөр, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 100.1 сая төгрөгөөр, газрын төлбөрийг

33.3 сая төгрөгөөр давж биелсэн, үйлдвэр үйлчилгээний зориулалттай усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 59.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт-12 БНАТ-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл / сая төгрөг/

№	Аймаг сумын нэр	2021 он			2022		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Алтай сум	1.6	0.6	0.9	2.1	3.7	(1.5)
2	Баян-Уул сум	21.2	110.5	(89.4)	73.0	2.4	70.6
3	Бигэр сум	9.7	14.9	(5.2)	40.1	12.7	27.4
4	Бугат сум	3.2	2.1	1.2	4.0	95.3	(91.3)
5	Дарив сум	1.1	1.0	0.1	4.4	4.6	(0.2)
6	Дэлгэр сум	3.1	3.5	(0.4)	10.0	10.9	(0.9)
7	Гуулин тосгон	1.2	-	1.2	0.2	-	0.2
8	Жаргалан сум	1.9	8.7	(6.9)	15.7	16.2	(0.5)
9	Тайшир сум	10.2	9.7	0.5	20.7	17.5	3.2
10	Тонхил сум	3.0	9.6	(6.6)	19.0	33.3	(14.3)
11	Төгрөг сум	9.5	9.5	0.0	25.8	26.0	(0.2)
12	Халиун сум	2.0	1.7	0.3	4.7	7.2	(2.4)
13	Хөхморьт сум	0.2	0.9	(0.6)	5.4	6.3	(0.9)
14	Цогт сум	1.3	7.5	(6.2)	45.5	50.7	(5.1)
15	Баянтоорой тосгон	0.2	0.4	(0.2)	0.2	0.2	-
16	Цээл сум	33.3	43.1	(9.8)	35.9	37.4	(1.5)
17	Чандмань сум	42.2	38.6	3.6	32.0	32.5	(0.5)
18	Шарга сум	1.9	1.5	0.4	2.9	3.2	(0.3)
19	Эрдэнэ сум	1.0	1.2	(0.1)	2.2	65.3	(63.1)
20	Есөнбулаг сум	46.7	47.8	(1.2)	350.9	339.0	11.9
21	Аймаг /Татвар	429.4	268.8	160.6	180.0	192.6	(12.6)
	Дүн	623.8	581.6	42.2	874.9	956.8	(81.9)

Эх сурвалж: Аймгийн 2021-2022 оны Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлангийн аудит

Сумууд БНАТ-ийн орлогыг төлөвлөхдөө ашиглах зөвшөөрөлтэй уялдуулж, судалгаа тооцоо хийхгүйгээр баталсан байна. Тухайлбал:

- ✓ Жаргалан, Халиун, Есөнбулаг сум 2021 онд 0.04 сая төгрөгийн, 2022 онд 2.1 сая төгрөгийн ойн нөөцийн төлбөрийг ямар ч төлөвлөгөөгүй төвлөрүүлсэн.
- ✓ Есөнбулаг сум 2022 онд төлөвлөсөн орлогогүй 0.2 сая төгрөгийн байгалийн ургамал ашигласны төлбөр оруулсан.
- ✓ Баян-Уул, Дэлгэр, Жаргалан, Цогт, Эрдэнэ сумууд батлагдсан төлөвлөгөөгүй 2021 онд 110.3 сая төгрөгийн, 2022 онд 171.0 сая төгрөгийн ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг төвлөрүүлсэн.

Б1.4.2. Усны нөөц ашигласан төлбөрийн ногдуулалт, төвлөрүүлэлт:

БОАЖГ-ын усны нөөц, ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтний тооцоогоор үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар дүгнэлтгүй ус ашигласан 26 хуулийн этгээдийн 100.3 сая төгрөгийн, дүгнэлттэй 8 ус ашиглагчийн 26.8 сая төгрөгийн усны төлбөрийг төлүүлээгүй үлдэгдэлтэй байна.

Харин Татварын Ерөнхий газраас ирүүлсэн өрийн мэдээллээр үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар ус ашигласан хуулийн этгээдийн 24.4 сая төгрөгийн, унд ахуйн зориулалтаар ус ашигласан хуулийн этгээдийн 1.1 сая төгрөгийн усны төлбөрийг төлүүлээгүй үлдэгдэлтэй байна.

Усны тухай хуулиар сумын байгаль хамгаалагч нь ус ашигласны төлбөрийг хууль тогтоомжийн дагуу ногдуулж, төлөлтөд хяналт тавихаар заасан боловч байгаль хамгаалагчид ногдуулалтыг хийдэггүй, ус ашиглалтын төлбөр аймагт орж байгаагаас төлбөрийг орсон эсэхийг тулган баталгаажуулдаггүй байна. Мөн ус ашиглалтын төлбөрөө хугацаанд төлөөгүй хуулийн этгээдийн ус ашиглалтын гэрээг цуцалж үйл

ажиллагааг зогсоох эрх гэрээ байгуулагч талд байх боловч эрх үүргээ хэрэгжүүлэхгүй байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар усны нөөцөд учруулсан хохиролд байгаль орчны хяналтын улсын байцаагч нөхөн төлбөр ногдуулна гэж заасан. Гэвч байгаль орчны хяналтын улсын байцаагч хуулиар олгогдсон эрхийн дагуу хяналтаа хэрэгжүүлэхгүй, нөхөн төлбөр ногдуулахгүйгээс БОАЖГ-ын мэргэжилтний тооцсон усны төлбөрийг ногдуулах, төлүүлэх асуудлыг хэрэгжүүлээгүй байна.

Татварын Ерөнхий хуулиар Татварын алба тайланг хүлээн авахдаа татвар төлөгчдийн татварын ногдуулалт, төлөлтийг үнэн зөв тодорхойлсон эсэхийг хянаж баталгаажуулах, мэдээлэл зөрүүтэй тохиолдолд анхан шатны болон холбогдох баримтыг шаардаж авахаар заасан боловч дээрх хяналт сул байгаагаас шалтгаалан ус ашиглагч нарын татварын тайлан зөрүүтэй байна. Тухайлбал:

- ✓ Аудитаар 2021, 2022 онд үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар дүгнэлт гаргуулсан хуулийн этгээдийн ашигласан усны төлбөрийг Татварын Ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй тулган үзэхэд усны дүгнэлт, ус ашиглалтын тайлан 23.5 сая төгрөгөөр, төлөгдсөн усны төлбөрийн дүн нь төрийн сангийн хуулгаар төлөгдсөн дүнгээс 11.1 сая төгрөгөөр, өрийн үлдэгдэл 5.1 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй.
- ✓ Мөн унд ахуйн зориулалтаар дүгнэлт гаргуулсан хуулийн этгээдийн ашигласан усны төлбөрийг Татварын Ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй тулган үзэхэд ус ашигласны төлбөрийн ногдуулалт 2.9 сая төгрөгөөр, төлөгдсөн усны төлбөрийн дүн нь төрийн сангийн хуулгаар төлөгдсөн дүнгээс 0.4 сая төгрөгөөр, өрийн үлдэгдэл 0.9 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй.

БНАТ-ийн тухай хуулийн 23.1-т “Сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна” гэж заасан боловч сумдад уг албан тушаалтныг томилоогүй, сумын байгаль хамгаалагч, байгаль орчны улсын байцаагч нар нь сумын татварын байцаагчид тайлан мэдээгээ бүрэн өгдөггүй, солилцдоггүйтэй холбоотой.

Аудитаар сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагчийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан тусгай шаардлагыг үзэхэд Бугат, Жаргалан, Тайшир, Тонхил, Халиун, Хөхморьт, Чандмань сумын улсын байцаагч мэргэжлийн бус байна. Мөн Цогт сум байгаль орчны хяналтын улсын байцаагчгүй байна. Дарив, Жаргалан, Тонхил, Халиун, Цээл, Есөнбулаг сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч нар нь улсын байцаагчийн эрхгүй байна.

Халиун, Шарга сумдын төсөвт байгууллагууд ус рашааны төлбөр 2.2 сая төгрөгийг төлжээ. Эдгээр байгууллагууд нь ус ашиглагч биш байтал нэг талаас сумын орон нутгийн орлогод ус, рашаан ашигласны төлбөр төлүүлэхээр, нөгөө талаас байгууллагын төсөвт зардлыг хий төлөвлөж байгаа нь үндэслэлгүй байна.

Төсвийн тухай хуулиар үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийг аймгийн орлогод төвлөрүүлэхээр заасан байтал 3.2 сая төгрөгийг Бугат сумын ус рашааны орлогод төвлөрүүлсэн байна.

Б1.4.3. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт, төвлөрүүлэлт:

Ан агнуурын орлогыг байгаль орчин аялал жуулчлалын сайдын олгосон зөвшөөрлийн дагуу харьяа сумын анхан шатны баримттай тулган төлөлтийг тухайн өдрийн долларын ханшаар тулгаж баталгаажууллаа.

Хүснэгт-13 БНАТ-ийн орлогын ногдуулалт, гүйцэтгэл / сая төгрөг/

№	Сумын нэр	Амьтны тоо	2021 он			Амьтны тоо	2022 он		
			Аудитаар төлбөл зохих	Төлсөн дүн	Зөрүү		Аудитаар төлбөл зохих	Төлсөн дүн	Зөрүү
1	Тонхил сум	1	7.3	7.3	0	5	28.9	28.9	0
2	Баян-Уул сум	4	109.2	109.2	0				0

3	Жаргалан сум	1	7.4	7.4	1.7	2	13.5	13.5	0
4	Дэлгэр сум	40	0.4	0.4	0				0
5	Эрдэнэ сум					2	63.1	63.1	0
6	Цогт сум					3	46.4	46.4	0
7	Есөнбулаг сум					4	126.1	126.1	0
8	Бугат сум					4	88.0	88.0	0
9	Дарив сум							2.1	(2.1)
	Дүн	46	124.3	124.3	1.7	20	366.0	368.1	(2.1)

Эх сурвалж: Гүйцэтгэл-орон нутгийн орлогын дансны хууль

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын тушаалаар 2021 онд 21 ан амьтан агнах зөвшөөрөл олгосноос 7 амьтан агнаж 123.9 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн. Дэлгэр суманд 40 ширхэг ногтрууг амьдаар нь барьж гаршуулан үржүүлэх зориулалтаар зөвшөөрөл олгосноор 0.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

2022 онд зөвшөөрлийн дагуу 20 ан амьтан агнуулсны төлбөр болох 366.0 сая төгрөгийг төсөвт бүрэн төвлөрүүлсэн. Авралын эрэлд ХХК нь Дарив суманд гаршуулж үржүүлэх зорилгоор ашигласан 60 ширхэг тарваганы үнэ болох 2.1 сая төгрөгийн төвлөрүүлсэн.

Аудитаар ан амьтны нөөц ашигласны ногдуулалтыг Татварын Ерөнхий газрын мэдээлэлтэй тулгаж үзэхэд 2021 онд ногдуулалт 71.5 сая төгрөгөөр илүү, 0.4 сая төгрөгөөр дутуу, 2022 онд 7.0 сая төгрөгөөр илүү, 219.7 сая төгрөгөөр дутуу ногдуулсан.

Б1.4.4. Ойн нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт, төвлөрүүлэлт:

Говь-Алтай аймгийн шинэсэн ойд цэвэрлэгээний ажил хийх замаар 800м³ түлээний мод бэлтгэх дээд хязгаарыг Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2022 оны тушаалаар баталсан байна. Гүйцэтгэлээр 214 м³ модыг бэлтгэж 2.1 сая төгрөгийг төвлөрүүлэхээс Есөнбулаг сумд 0.1 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн. Харин Жаргалан сумд 0.2 сая төгрөгийг илүү төвлөрүүлсэн боловч эзэн нь тодорхойгүй байна.

Ойн нөөц ашигласны төлбөрийг Татварын Ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй тулган үзэхэд 0.2 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Алтай сумд өмнөх онуудын орлогыг нөхөн тайлагнуулсантай холбоотой. 2022 оны тухайд ногдуулалт, төлөлт зөрүүгүй байна.

Б1.4.5. Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр ногдуулалт, төвлөрүүлэлт

2021-2022 онд байгалийн ургамал ашиглахаар төлөвлөлт хийгдээгүй бөгөөд гүйцэтгэлээр Есөнбулаг сумын дансанд 0.2 сая төгрөг төвлөрсөн байна. Татвар ерөнхий газрын нь 2021 онд 0.008 сая төгрөг, 2022 онд 1.4 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Говь-Алтай аймгийн хэмжээнд суль, сулхир, хармаг, чацарганыг байгалиас бэлтгэж худалдан борлуулдаг боловч БНАТ ашигласны төлбөр ногдуулдаггүй, хяналт тавьдаггүй байна.

Б2. Төлбөрийн орлогын хэсгийг хуулийн дагуу төлөвлөж, зарцуулаагүй байна.

Б2.1. Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээний дагуу менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөөгүй байна.

Б2.1.1. Аймаг, сумын ИТХ-аар БНАТ-ийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах дүнг батлахдаа БНАТ-ийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1¹³-т заасан хувь, хэмжээний доод хязгаарыг мөрдөөгүй байна. Тухайлбал:

¹³18.1.Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

- ✓ Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгээс 2021 онд зардал батлаагүй, 2023 онд 33 хувийг зарцуулахаар
- ✓ Ан, амьтны нөөц ашигласны төлбөрөөс 2022 онд 45 хувийг, 2023 онд 37 хувийг зарцуулахаар
- ✓ Ус, рашааны нөөц ашигласны төлбөрөөс 2021-2023 онуудад 32-34 хувийг зарцуулахаар
- ✓ Газрын төлбөрөөс 2022 онд зардал батлаагүй, 2023 онд 9 хувийг зарцуулахаар тус тус баталсан.

Б2.1.2. Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.12¹⁴-т заасны дагуу БНАТ-ийн орлогын төлөвлөгөөнөөс давсан хэсгээр санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр боловсруулахаар байна. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 2022 онд 84.1 сая төгрөгөөр, 2023 онд 87.7 сая төгрөгөөр дутуу баталсан.

Хүснэгт-14. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулбал зохих зардлын төлөвлөгөө-2022 он /сая.төг/

№	Орлогын төрөл	Он	Орлогын төлөвлөгөө			Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал				
			Өмнөх оны давсан орлого	Тайлант оны төлөвлөгөө	Нийт орлого	Хуульд заасан доод хувь хэмжээ	Зардлын доод хязгаар	Батлагдсан төсөв	Зөрүү	Төлбөрийн орлогын эзлэх хувь
1	Ойн нөөц ашигласны төлбөр	2021	1.5	-	1.5	85%	1.2	-	-1.2	0%
		2022	0.0	-	0.0		0.0	-	0.0	0%
		2023	2.2	1.4	3.6		3.1	1.2	-1.9	33%
2	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2021	-	20.0	20.0	50%	10.0	20.0	10.0	100%
		2022	96.3	268.7	365.0		182.5	163.6	-18.9	45%
		2023	171.1	162.2	333.3		166.7	123.2	-43.5	37%
3	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	2021	28.1	164.0	192.1	35%	67.2	61.2	-6.1	32%
		2022	2.3	182.8	185.1		64.8	63.0	-1.8	34%
		2023	5.3	266.6	271.9		95.2	92.8	-2.3	34%
4	Газрын төлбөр	2021	10.7	439.8	450.4	15%	67.6	61.2	-6.4	14%
		2022	16.1	423.3	439.5		65.9	0.7	-65.2	0%
		2023	77.4	600.4	677.8		101.7	59.4	-42.3	9%
Дүн		2021	40.2	623.8	664.0		146.0	142.3	2.4	17%
		2022	114.8	874.9	989.6		313.3	227.3	(84.1)	20%
		2023	256.0	1,030.7	1,286.7		366.6	276.6	(87.7)	18%

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Б2.1.3. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд 2021 онд 8, 2022 онд 13, 2023 онд 24 ажлыг төлөвлөж тусгасан боловч менежентийн төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээ 78 хувийг эзэлж байна.

Б2.1.4. БНАТ-ийн орлогоос 2021-2023 онд тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөснөөс журамд нийцээгүй зориулалт бус арга хэмжээнд 102.8 сая төгрөгийг төсөвлөсөн байна. Тухайлбал:

- ✓ Баян-Уул сумын ИТХ-ын 2022 оны төсөв батлах тухай тогтоолд ан, агнуурын орлогоос 2021 онд төвлөрсөн 71.0 сая төгрөгийг хог хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд баталсан.
- ✓ Бугат сумын ИТХ-ын 2023 оны төсөв батлах тухай тогтоолд ан, агнуурын орлогоос 10.0 сая төгрөгийг сумын төвд сад засварлах зардалд баталсан.

Б2.2. БНАТ-ийн орлогын 12-21 хувийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулсан байна.

Б2.2.1. Аймаг, сумын ИТХ-аар БНАТ-ийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулсан хувь хэмжээ

¹⁴ 3.12.Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэсгээр санхүүжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-4-Б маягтын дагуу жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор боловсруулна.

хуульд заасан доод хязгаараас бага 2021 онд 30.7 сая төгрөгөөр, 2022 онд 226.6 сая төгрөгөөр дутуу зарцуулжээ. Тухайлбал:

- ✓ Ойн нөөц ашигласны төлбөрөөс 2020 оны давсан орлогоос 1.5 сая, 2022 онд 2.2 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн боловч байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулаагүй.
- ✓ Ан, амьтны нөөц ашигласны төлбөрөөс 2021 онд 130.3, 2022 онд 368.8 сая төгрөг бүрдүүлсэн боловч 17 хувь буюу 82.3 сая төгрөгийг зарцуулсан.
- ✓ Ус, рашааны нөөц ашигласны төлбөрөөс 2020 оны давсан орлогоос 28.1 сая, 2021 онд 120.4 сая, 2022 онд 128.9 сая төгрөг бүрдүүлсэн боловч 101.9 сая төгрөгийг зарцуулсан гэж тайлагнасан нь нийт орлогын 36.7 хувийг эзэлж байна.
- ✓ Газрын төлбөрөөс 2020 оны давсан орлогоос 10.7 сая, 2021 онд 330.9 сая, 2022 онд 456.6 сая төгрөг бүрдүүлсэн боловч 98.8 сая төгрөгийг зарцуулснаар тайлагнасан нь нийт орлогын 12.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт-15. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан зардлын тооцоо-2022 он /сая.төг/

№	Орлогын төрөл	Он	Орлогын гүйцэтгэл			Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал				
			Өмнөх оны давсан орлого	Тайлант оны орлого	Нийт орлого	Хуульд заасан доод хувь хэмжээ	Зардлын доод хязгаар	Зарцуулсан	Зөрүү	Төлбөрийн орлогын эзлэх хувь
1	Ойн нөөц ашигласны төлбөр	2021	1.5	0.0	1.5	85%	1.3	-	-1.3	0%
		2022	0.0	2.2	2.2		1.9	-	-1.9	0%
		2023	2.2	-	2.2		1.9	-	-1.9	0%
2	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2021	-	130.3	130.3	50%	65.2	-	-65.2	0%
		2022	96.3	368.8	465.1		232.6	82.3	-150.3	18%
		2023	171.1	-	171.1		85.6	-	-85.6	0%
3	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	2021	28.1	120.4	148.5	35%	42.1	36.4	-5.7	25%
		2022	2.3	128.9	131.2		45.1	35.5	-9.6	27%
		2023	5.3	-	5.3		-	30.0	30.0	571%
4	Газрын төлбөр	2021	10.7	330.9	341.6	15%	51.2	92.7	41.4	27%
		2022	16.1	456.6	472.8		70.9	6.1	-64.8	1%
		2023	77.4	0.0	77.4		11.8	-	-11.8	0%
Дүн		2021	40.2	581.6	621.8		159.8	129.1	(30.7)	21%
		2022	114.8	956.6	1,071.4		350.5	123.9	(226.6)	12%
		2023	256.0	0.0	256.0		99.0	30.0	(69.0)	12%

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Б2.2.2. БНАТ-ийн орлогоос 2021-2023 онд зарцуулсан 283.0 сая төгрөгийн зардлын зориулалтыг үзэхэд 30.2 сая төгрөгийг журамд нийцээгүй арга хэмжээнд зарцуулсан. Тухайлбал:

- ✓ Дарив сум ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого 2.1 сая төгрөгийг хууль бус алтны эргүүл, хяналт хийх тээвэр шатахууны зардалд зарцуулсан.
- ✓ Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын 50-с доошгүй хувийг тухайн нөөцийг нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээнд зарцуулахаар хуульчилсан. Гэтэл Баян-Уул сум нь ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын 36 хувийг тухайн нөөцийг хамгаалах арга хэмжээнд зарцуулан 18.1 сая төгрөгийг хог хөтөлбөрт зарцуулжээ.
- ✓ Цогт сум нь мөн адил ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын 50-с доошгүй хувийг тухайн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулаагүй 10.0 сая төгрөгийн мод тарьсан байна.

БОАЖГ нь ус рашааны нөөц ашигласны төлбөрөөс 31.9 сая төгрөгийг аялал жуулчлалын бүс дагуу гол нуурын нөлөөлөлд өртөж буй газруудад стандартын шаардлагад нийцсэн хогийн бункер хийж байршуулах зардалд, газрын төлбөрөөс 8.2 сая төгрөгийг мотоцикл тээврийн хэрэгсэл худалдан авах зардалд зарцуулжээ.

Б2.2.3. Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралт “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг

бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.1¹⁵, 3.2¹⁶-д заасны дагуу БНАТ-ийн орлогыг тухайн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулахаас гадна бусад төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг харгалзахгүйгээр байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулахаар байна.

Хүснэгт-16 БНАТ-ийн орлого, зардал, төсөл, мөнгөн хөрөнгийн судалгаа /сая. төгрөг/

№	Сумын нэр	2021-2022 он					2023 он		
		БНАТ-ын орлого /2021-2022 он/	Хуулийн дагуу зарцуулалт /2021-2022 он/	Байвал зохих зарцуулаагүй мөнгөн хөрөнгө /2022 он/	Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /2022 он/	Зориулалт бусаар зарцуулсан БНАТ орлого /2021-2022 он/ +/-	2023 оны БНАТ-ын орлогын төлөвлөгөө	Зарцуулахаар төлөвлөсөн	Төсөвт байгууллагын урсгал зардалд төсөвлөсөн дүн
1	Алтай сум	4.3	-	4.3	57.5		68.0	-	68.0
2	Баян-Уул сум	113.0	38.2	74.8	87.5		3.0	-	3.0
3	Бигэр сум	27.6	-	27.6	145.5		69.2	-	69.2
4	Бугат сум	97.3	-	97.3	316.9		26.6	75.0	
5	Дарив сум	5.5	2.4	3.1	75.3		5.7	-	5.7
6	Дэлгэр сум /Гуулин тосгон/	14.4	-	14.4	120.4		10.2	-	10.2
7	Жаргалан сум	24.9	-	24.9	221.9		18.7	9.4	9.4
8	Тайшир сум	27.2	-	27.2	96.0		19.5	-	19.5
9	Тонхил сум	42.9	-	42.9	132.5		27.0	-	27.0
10	Төгрөг сум	35.5	-	35.5	63.4		46.0	-	46.0
11	Халиун сум	8.9	-	8.9	56.6		11.3	5.4	5.9
12	Хөхморьт сум	7.2	-	7.2	54.9		5.4	0.8	4.6
13	Цогт сум /Баянтоорой тосгон/	58.7	19.0	39.7	76.9		23.7	10.5	13.2
14	Цээл сум	80.5	-	80.5	64.2	16.3	118.5	17.6	100.9
15	Чандмань сум	71.1	-	71.1	215.8		85.0	-	85.0
16	Шарга сум	4.6	-	4.6	72.5		3.0	0.4	2.6
17	Эрдэнэ сум	66.5	-	66.5	117.4		2.3	31.5	
18	Есөнбулаг сум	386.8	23.0	363.8	292.0	71.9	223.7	33.6	190.1
19	Аймаг	461.4	170.4	291.0	2,267.1		263.8	92.3	171.5
	Нийт	1,538.4	253.0	1,285.4	4,534.2	88.2	1,030.7	276.6	831.8

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Дээрх судалгаанаас үзэхэд аймгийн хэмжээнд 2021-2022 онд нийт 1,538.4 сая төгрөгийн БНАТ-ийн орлого төвлөрүүлснээс 253.0 сая төгрөгийг хуулийн дагуу зарцуулсныг хасаж тооцвол 1,285.4 сая төгрөгийн орлогын үлдэгдэл төрийн сангийн дансанд байх ёстой. БНАТ-ийн орлогын байвал зохих зарцуулаагүй мөнгөн хөрөнгийг аймаг, сумдын төрийн сангийн орон нутгийн орлогын мөнгөн хөрөнгөтэй тулган үзэхэд Цээл сум 16.3 сая

¹⁵ 3.1.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаартай тэнцэх төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.

¹⁶ 3.2.Энэ журмын 3.1-д зааснаас бусад төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг харгалзахгүйгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.

төгрөгийн, Есөнбулаг сум 71.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсөвт байгууллагын урсгал зардалд зарцуулсан байна.

Мөн аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор батлагдсан 2023 оны төсвийг үзэхэд 831.8 сая төгрөгийг төсөвт байгууллагын урсгал зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.

БҮЛЭГ В. БНАТ-ИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ ТОХИРОХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

В1. Төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын ажлын уялдаа холбоогүйгээс байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын нэгдсэн мэдээлэл зөрүүтэй байна.

В1.1. Мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт хангалтгүй, мэдээлэл зөрүүтэй, олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.

Хүснэгт-17 Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн зөрүү-2022 он /сая.төг/

Орлогын төлөвлөгөө- www.eic.mn/finance	782.4
Орлогын төлөвлөгөө- аудитаар	874.9
Орлогын гүйцэтгэл- www.eic.mn/finance-	717.2
Орлогын гүйцэтгэл-аудитаар	956.6
Өмнөх оны давсан орлого- www.eic.mn/finance	109.0
Өмнөх оны давсан орлого- аудитаар	114.8
Зардлын төлөвлөгөө- www.eic.mn/finance	212.7
Зардлын төлөвлөгөө- аудитаар	128.5
Зардлын гүйцэтгэл- www.eic.mn/finance	295.6
Зардлын гүйцэтгэл-аудитаар	123.9

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-т “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулна”¹⁷ гэж заасан бөгөөд <https://www.eic.mn/> цахим системийг Байгаль орчны мэдээллийн төвөөс хөгжүүлэн ашиглаж байна. Мөн “Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардал”-ийн мэдээллийн санг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд “Биофин” төсөлтэй хамтран хөгжүүлж байна. БНАТ-ийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар 2022 онд төлөвлөсөн, зарцуулсан хөрөнгийн хувь хэмжээг зөрүүтэй мэдээлсэн байна.

Эх сурвалж: www.eic.mn/finance, аудитын ажлын баримт

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын цахим сангийн мэдээллээр 2022 онд 782.4 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 717.2 сая төгрөгийг орлого төвлөрүүлснээс, 295.6 сая төгрөгийг зарцуулсан байна. Аудитаар тулган баталгаажуулахад 2022 онд 874.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталснаас гүйцэтгэлээр 956.6 сая төгрөгийн орлого төвлөрч, 123.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Мөн www.eic.mn/finance цахим хуудсанд өмнөх оны давсан орлогыг мэдээлээгүй, Орон нутгийн хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлсэн 85.2 сая төгрөгийн арга, хэмжээг тайлагнасан. Мөн огт хэрэгжүүлээгүй 86.5 сая төгрөгийн арга, хэмжээг хэрэгжүүлснээр тайлагнасан байна.

Улмаар байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих бодлого шийдвэр боловсруулах чиг үүрэгтэй дээд шатны удирдлага, шийдвэр гаргах эрх бүхий газрыг зөрүүтэй, ташаа мэдээллээр хангаж байна.

¹⁷ 2.9/“байгаль орчны мэдээллийн сан” /цаашид “мэдээллийн сан” гэх/ гэж байгаль орчны өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, цуглуулах, дамжуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, баяжуулах, өөрчлөх, шинэчлэх, хамгаалах зэрэг үйл ажиллагааг хангах мэдээллийн технологийн иж бүрдлийг;

Цаашид мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хянах, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистик, дүн мэдээтэй тулган баталгаажуулж, системийн шинэчлэл хийх нь зүйтэй байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 4.9¹⁸-т заасан нөхөн сэргээгдэх байгалийн баялгийн төлбөрийн тодорхой хувийг тухайн байгалийн баялгийг хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаанд зарцуулж байгаа эсэх тайланг олон нийтэд мэдээлээгүй, олон нийт хяналт тавих боломжийг хангаагүй байна.

В1.2 БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтэд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, ажлын уялдаа холбоо нэн чухал үүрэгтэй.

Хүснэгт-18 БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтэд төрийн байгууллагуудын оролцоо

Хариуцах этгээд	Чиг үүрэг
ИТХ	БНАТ-ийн орлого, зарлагын төлөвлөгөөг батлах, хяналт тавих
Засаг дарга	Байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулах, төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалтын тайланг хүргүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах, төлбөрийн орлогын хэсгийг зарцуулах санал боловсруулж ИТХ-д хүргүүлэх
Татварын хэлтэс, сумын татварын байцаагч	байгалийн нөөцийг ашиглах зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэх
БОАЖГ, Сум дундын ойн анги	Орлогын төлөвлөгөөг нэгтгэж, жилийн төсвийн саналд тусгуулахаар аймгийн Засаг даргад хүргүүлэх, ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих
БОХУБ	байгаль орчны хууль тогтоомжийн зөрчлийн торгууль, нөхөн төлбөр, хураагдсан эд зүйлс, байгалийн баялгийг борлуулсны орлогыг зохих шатны төсөвт төвлөрүүлэх;
Сав газрын захиргаа	Ус, рашааны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг хамтран хэрэгжүүлэх

Эх сурвалж: Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь байгаль хамгаалах арга хэмжээний төсөв, зардлыг мэдээллийн санд бүрэн оруулсан эсэхэд хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

БНАТ-ын 2022 онд төвлөрүүлсэн орлого Татварын Ерөнхий газрын мэдээгээр 930.0 сая, аймгийн Санхүү, төрийн сангийн мэдээгээр 956.4 сая, eic.mn/finance системийн мэдээгээр 717.2 сая төгрөг байна. Тухайлбал байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын цахим санд БНАТ-ын төлбөрийн орлогын гүйцэтгэлийн 2022 онд мэдээлээгүй, дутуу мэдээлсэн байна.

Хүснэгт-19 Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сангийн зөрүү-2022 он /сая.төг/

¹⁸4.9 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтыг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан өдөр тутмын болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын албан ёсны цахим хуудсаар олон нийтэд түгээнэ.



Эх сурвалж: www.eic.mn/finance, ТЕГ, Санхүү, төрийн сангийн хэлтэс

В2. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийж үр дүнг хэлэлцээгүй байна.

В2.1. Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Салбарын хөгжлийн чиг баримтлалд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг тухайлан тусгаж, байгаль хамгаалах тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ зохион байгуулж үр дүнг Засгийн газарт тайлагнасан байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “БНАТ-ийн тухай хууль”, “Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийн 2021, 2022 оны дүн, тайланд хяналт, шинжилгээ хийж дүгнэлт зөвлөмж өгсөн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас гаргасан судалгааны дагуу хуулийн хэрэгжилтийг 2021 онд 82%, 2022 онд 19%-тай гэж дүгнэжээ. Аудитаар дахин тооцоолж үзлээ.

Хүснэгт-20		БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилт /сая.төгрөг/					
№	Сумын нэр	Хуулийн дагуу зарцуулбал зохих доод хэмжээ		Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтэд зарцуулсан дүн		Хуулийн хэрэгжилтийн хувь	
		2021 он	2022 он	2021 он	2022 он	2021 он	2022 он
1	Алтай	0.2	0.6	0	0	0%	0%
2	Баян-Уул	54.8	38.0	0	20.0	0%	53%
3	Бигэр	2.3	2.6	0	0	0%	0%
4	Бугат	0.3	45.7	0	0	0%	0%
5	Дарив	0.1	1.4	0	0.3	0%	24%
6	Дэлгэр	0.7	1.8	0	0	0%	0%
7	Жаргалан	4.0	11.2	0	0	0%	0%
8	Тайшир	1.9	2.6	0	0	0%	0%
9	Тонхил	4.0	18.8	0	0	0%	0%
10	Төгрөг	1.4	3.9	0	0	0%	0%
11	Халиун	1.7	2.4	0	0	0%	0%
12	Хөхморьт	0.1	1.1	0	0	0%	0%
13	Цогт	3.3	27.2	0	9.0	0%	33%
14	Цээл	9.2	7.4	0	0	0%	0%
15	Чандмань	5.8	5.0	0	0	0%	0%
16	Шарга	0.3	0.6	0	0	0%	0%
17	Эрдэнэ	0.2	31.9	0	0	0%	0%
18	Есөнбулаг	8.1	95.3	0	23.0	0%	24%
19	Аймаг /БОАЖГ/	61.1	53.0	129.1	41.3	211%	78%
Нийт дүн		159.8	350.5	129.1	93.6	81%	27%

Эх сурвалж: Аудитын ажлын баримт

Дээрх судалгаанаас үзэхэд Алтай, Бигэр, Бугат, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Тонхил, Төгрөг, Халиун, Хөхморьт, Чандмань, Шарга, Эрдэнэ сумын хувьд БНАТ-ын хуулийн хэрэгжилт “0” хувьтай байна.

Харин Говь-Алтай аймгийн БОАЖГ-т зарцуулагдсан байгаль, хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын гүйцэтгэлээс тооцсон БНАТ-ийн хуулийн хэрэгжилт өндөр байгаа нь сумын хуулийн хэрэгжилт “0” байсан ч аймгийн нийт хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлж байна.

В2.2. Тайшир, Есөнбулаг, Чандмань сумаас бусад сумын нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуулийн хэрэгжилтэд хяналт тавиагүй байна.

В2.2.1. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралтын 3.17, 3.18, 3.19, 3.20, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т тус тус зааснаар нутгийн өөрөө удирдах байгууллага нь сум, дүүрэгтээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих эрхтэйг заасан.

Нутгийн өөрөө удирдах байгууллагаас Тайшир, Есөнбулаг, Чандмань сумд 2021-2022 онуудад байгалийн нөөцтэй холбоотой 5 хяналт, шалгалтыг хийж бусад сумууд хяналт шалгалт огт хийгээгүй байна. Үүнд:

- ✓ Тайшир сумд төлөвлөгөөт бус хяналтыг хийж алтны илэрц бүхий газруудад хууль бусаар газар ухаж хөндсөн, Галуут багийн нутагт аймгийн төвийн хатуу хог хаягдлыг ландшафтийн аргаар булшлах нүх ухаж байсан, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч компани нь хайгуулын ажил, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаадаагүй ажил гүйцэтгэж байсан зэрэг зөрчлүүдийг илрүүлж зөрчлийг арилгуулан үр дүнг тооцсон байна.
- ✓ Есөнбулаг сумд 2022 онд төлөвлөгөөт хяналт, шалгалтыг хийж Наран багийн нутагт үйл ажиллагаа явуулж буй "Хан алтай ресурс" ХХК-ийн алтны ордны үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хэлэлцүүлээгүй зөрчлийг илрүүлэн үр дүнг сумын ИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлж хурлын тэмдэглэлээр анхаарах асуудлыг хүргүүлсэн байна.
- ✓ Чандмань сумд 2021-2022 онуудад байгалийн нөөцтэй холбоотой төлөвлөгөөт бус хяналтыг хийсэн боловч үр дүнг тооцон ажиллаагүй байна.

Нутгийн өөрөө удирдах байгууллагаас зарим сумд байгалийн нөөцтэй холбоотой төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналтыг хийж байгаа хэдий ч байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг мэргэжлийн болон төрийн бус байгууллага, бүлэг, нөхөрлөл, иргэд, малчидтай хамтран хэрэгжүүлээгүй, хяналт шалгалтыг хийх төлөвлөгөөг батлаагүй, байгалийн нөөцийн талаарх хууль эрх зүйн мэдлэг дутмаг байгаагаас эрх бүхий байгууллага хяналт хийгээгүй, үйл ажиллагаа жигдрээгүй байна.

ИЛРҮҮЛЭЛТ:

БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар 3,729.2 сая төгрөгийн зөрчил илэрч 950.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага, 2,778.3 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлээ.

БНАТ-ийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх:

1. Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичгийг батлахдаа шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тооцож төлөвлөөгүй.
2. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн болон ойн менежментийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлээгүй.
3. Аймгийн Засаг дарга нь сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээнд БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтийг тусгаагүй.

Байгалийн нөөц ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгосон эсэх:

4. Ус ашиглах дүгнэлтгүйгээр 2021 онд 17, 2022 онд 23 хуулийн этгээд үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ус ашигласан.
5. Ус ашиглуулах дүгнэлттэй боловч 2021 онд 12, 2022 онд 14 хуулийн этгээд сумын Засаг даргын зөвшөөрөлгүй ус ашигласан.
6. Ус ашиглуулах дүгнэлттэй боловч 2021 онд 14, 2022 онд 13 хуулийн этгээд гэрээ байгуулалгүйгээр ус ашигласан.
7. Усны тоолуургүйгээр 2021 онд 23, 2022 онд 29 хуулийн этгээд үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар ус ашигласан.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийг үндэслэлтэй төлөвлөж, ногдуулан, бүрэн төвлөрүүлсэн эсэх:

8. Байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулаагүй.
9. Бугат, Жаргалан, Тайшир, Тонхил, Халиун, Хөхморьт, Чандмань сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч мэргэжлийн бус, Цогт сум байгаль орчны хяналтын улсын байцаагчгүй байна.
10. Дарив, Жаргалан, Тонхил, Халиун, Цээл, Есөнбулаг сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч нар нь улсын байцаагчийн эрхгүй байна.
11. Шинэсэн ойд цэвэрлэгээний зориулалтаар ашигласан түлээний модны төлбөрөөс 0.1 сая төгрөгийг төлүүлээгүй.
12. Татварын тайлангаар үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар ус ашиглагч хуулийн этгээдийн 24.4 сая төгрөгийн усны төлбөрийн өрийн үлдэгдэл байна.
13. Аудитаар 2021, 2022 онд үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар дүгнэлт гаргуулсан хуулийн этгээдийн ашигласан усны төлбөрийг Татварын Ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй тулган үзэхэд усны дүгнэлт, ус ашиглалтын тайлан 23.5 сая төгрөгөөр, төлөгдсөн усны төлбөрийн дүн нь төрийн сангийн хуулгаар төлөгдсөн дүнгээс 11.1 сая төгрөгөөр, өрийн үлдэгдэл 5.1 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй.
14. Мөн унд ахуйн зориулалтаар дүгнэлт гаргуулсан хуулийн этгээдийн ашигласан усны төлбөрийг Татварын Ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй тулган үзэхэд ус ашигласны төлбөрийн ногдуулалт 2.9 сая төгрөгөөр, төлөгдсөн усны төлбөрийн дүн нь төрийн сангийн хуулгаар төлөгдсөн дүнгээс 0.4 сая төгрөгөөр, өрийн үлдэгдэл 0.9 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй.
15. Ан амьтны төлбөрийг Татварын Ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлтэй тулган үзэхэд ногдуулалт 300.8 сая төгрөгөөр зөрүүтэй.
16. Аймгийн ус рашааны орлогод төвлөрөх 3.3 сая төгрөгийн ус ашиглагчийг төлбөрийг сумын ус рашааны орлогод төвлөрүүлсэн.
17. Татварын тайлангаар унд ахуйн хэрэгцээнд ашигласан усны төлбөр 1.1 сая төгрөгийг төлүүлээгүй.
18. Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөлгүйгээр ашигласан 100.3 сая төгрөгийн, дүгнэлт гарсан 26.8 сая төгрөгийн усны төлбөрийг эрх бүхий албан тушаалтныг ажиллуулан төлүүлэх арга хэмжээ аваагүй байна.
19. Төсөвт байгууллагад үндэслэлгүйгээр ус ашигласны төлбөрийг ногдуулж 2021 онд 0.9 сая төгрөг, 2022 онд 1.2 сая төгрөгийг төлүүлсэн.

Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт хуулийн дагуу хэрэгжсэн эсэх:

20. Аймаг, сумдын 2021-2023 оны ИТХ-ын тогтоолоор БНАТ-ийн орлогоос 102.8 сая төгрөгийг зориулалт бус арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн.
21. 2023 оны сумын ИТХ-аар батлагдсан төсөвт дүн шинжилгээ хийхэд нийт 831.8 сая төгрөгийг төсөвт байгууллагын зардалд төлөвлөсөн.
22. БНАТ-ийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулсан хувь хэмжээний доод хязгаараас 2021 онд 98.6 сая төгрөгөөр, 2022 онд 216.0 сая төгрөгөөр дутуу зарцуулжээ.

23. Аймгийн хэмжээнд 2021-2022 онд нийт 1,285.4 сая төгрөгийн БНАТ-ийн орлогын үлдэгдэл төрийн санд байршиж байна.

24. БНАТ-ийн орлогоос 30.2 сая төгрөгийг менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй, журамд заагаагүй зориулалт бус арга хэмжээнд зарцуулсан.

Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сан үнэн зөв илэрхийлэгдэж, төрийн байгууллагуудын уялдаа холбоо оновчтой байгаа эсэх:

25. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн санд БНАТ-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, зардлын төлөвлөгөө гүйцэтгэлийг 661.0 сая төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн.

Хуулийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг хийж үр дүнг дүгнэсэн эсэх:

26. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг хэрэгжүүлээгүй, хяналт шалгалтыг хийгээгүй байна.

Дүгнэлт: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт 2021 онд 81 хувь, 2022 онд 27 хувьтай байна.

Аудитын явцад : цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд

1. Аймаг, сумдын ИТХ, Засаг дарга нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.
2. Аймаг, сумд төвлөрүүлэх ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй, зөрүүтэй тайлагнасан, мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт хангалтгүй, эрх бүхий байгууллагууд мэдээллээ бүрэн солилцдоггүй.
3. БНАТ-ийн орлогын хэсгээс байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг хууль, тогтоомжид заасны дагуу мөрдөөгүй.
4. Төрийн байгууллагын ажлын уялдаа холбоо дутмагаас БНАТ-ийн тухай хуулийн хэрэгжилт орон нутагт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймаг, сумын ИТХ-ын дарга нарт

1. Байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээг мэргэжлийн болон төрийн бус байгууллага, бүлэг, нөхөрлөл, иргэд, малчидтай хамтран хэрэгжүүлэх, хяналт шалгалтын удирдамж төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллах

Аймгийн Засаг даргад

1. Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулан эх үүсвэр зорилтод түвшнийг тодорхой болгох
2. Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн болон ойн менежментийн төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх

3. Сумдын Засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээнд БНАТ-ийн тухай хуулийг хэрэгжүүлэх чиг үүргийг тусгайлан зааж оруулах

БОАЖГ, Сумын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт

1. Байгаль хамгаалах арга хэмжээний төсөв, зардлыг мэдээллийн санд бүрэн оруулсан эсэхэд хяналт тавих үүргээ хэрэгжүүлэх

АЛБАН ШААРДЛАГА


Татварын хэлтэст

1. Үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар дүгнэлттэй ус ашиглагчийн усны төлбөрийн өрийн үлдэгдэл 24.4 сая төгрөгийг төлүүлэх
2. Үйлдвэр үйлчилгээний зориулалтаар ус ашиглах дүгнэлттэй хуулийн этгээдийн усны төлбөрийн тайлагнал, төлөлт, өрийн үлдэгдлийн зөрүүг хянаж, зөрчлийг арилгах ажил зохион байгуулах

Сумын Засаг дарга, байгаль орчны улсын байцаагч нарт

1. Байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилж ажиллуулах
2. Ажлын байрны тодорхойлолтод нийцсэн, улсын байцаагчийн эрхтэй байгаль орчны байцаагчийг ажиллуулах
3. Бугат сумын дансанд андуурч хийсэн үйлдвэр үйлчилгээний зориулалттай 3.2 сая төгрөгийн усны төлбөрийг аймгийн 1000500000944 тоот дансанд төвлөрүүлэх
4. Түлээний мод бэлтгэсэн иргэнээр 0.1 сая төгрөгийн ойн нөөц ашигласны төлбөрийг төлүүлэх
5. Дүгнэлт, зөвшөөрөлгүйгээр ус ашигласанд нөхөн төлбөр ногдуулж, төлбөрийг төлүүлэх
6. Ус болон ан амьтан ашигласны төлбөрийн ногдуулалт, төлөлт, өрийн үлдэгдлийн зөрүүг арилгуулах
7. Төсөвт байгууллагад үндэслэлгүйгээр усны төлбөр ногдуулж төлүүлдэг асуудлыг таслан зогсоох
8. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг журамд зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахгүй байх
9. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж зарцуулах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жаргалант баг, 82083
Цахим шуудан: govialtai.baigaliorchin@gmail.com
Цахим хуудас: gov-altai.nature.gov.mn
Утас/Факс: 70-48-49-54

2023.06.19 № 229

танай _____-ны № _____-т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн 2021-2022 оны орлогыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах чиглэлээр хийгдсэн дүгнэлттэй танилцлаа.

Хүлээн зөвшөөрч байна.

ДАРГЫН АЛБАНҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.БОЛДБААТАР



20000 131